

2023 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН
ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН

“НЭХИЙ ТАННЕРИ” ХХК

Дархан-Уул аймгийн Дархан сумын Үйлдвэрийн дүүрэг

/Тусгай зөвшөөрлийн дугаар: 0001565/

/Аж ахуйн нэгжийн РД: 2649624/

Хянасан:

Дархан-Уул аймгийн
БОАЖГ-ын мэргэжилтэн

А. Энхжин (А. Энхжин)

Хэрэгжилтийг гаргасан:

“Нэхий таннери” ХХК-ийн
Байгаль орчны мэргэжилтэн

А. Аюу-Утсан (А. Аюу-Утсан)

2023 он




Төсөл хэрэгжүүлэгч ААН-ийн нэр:
Төслийн байршил:
Тусгай зөвшөөрлийн дугаар:
Огноо:

"Нэхий таннери" ХХК
Дархан-Уул аймгийн Дархан сумын Үйлдвэрийн дүүрэг
0001565 /Химийн хорт болон аюултай бодисын хэрэглээ/
2023.12.15

№	Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний бүрэлдэхүүн хэсгүүд	Авсан байвал зохих оноо	Ажлын хэсгийн гишүүдийн үнэлсэн оноо						Гишүүдийн үнэлсэн онооны энгийн арифметик дундаж	Үндэслэл, тайлбар
			Гишүүн 1	Гишүүн 2	Гишүүн 3	Гишүүн 4	Гишүүн 5	Гишүүн 6		
1	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт	20	18	18	18	20	20	20	19	
2	Орчны тохижилт, нөхөн сэргээлтийн төлөвлөгөөний биелэлт	30	25	25	26	24	24	23	24.5	
3	Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний биелэлт	5	5	5	5	5	5	5	5	
4	Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөөний биелэлт	15	14	14	13	14	14	12	13.1	
5	Хог, хаягдлын менежментийн төлөвлөгөөний биелэлт	10	10	10	10	9	10	10	9.8	
6	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн биелэлт	10	8	8	8	8	8	10	8.6	
7	Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөөний биелэлт	5	5	5	5	5	5	5	5	
8	Нөлөөллийн бүсийн оршин суугчдад тайлагнах төлөвлөгөөний биелэлт	5	5	5	5	5	5	5	5	
	Нийт оноо	100	90	90	90	90	90	90	90	

Ажлын хэсгийн дарга:
Дархан-Уул аймгийн БОАЖГ-ын дарга

Нарийн бичгийн дарга:
БОАЖГ-ын газрын хэвлий, тусгай хамгаалалттай Газар нутаг, БОНБУнэлгээ хариуцсан мэргэжилтэн


 (Г.Батбаяр)
 (А.Энхжин)

Гишүүд:

Хараа ерөө сав газрын захиргааны ахлах мэргэжилтэн

 (Г.Оюунгэрэл)


Ус цаг уур, орчны шинжилгээний
Агаарын техникч

 (У.Алтанзул)

Дархан-Уул аймгийн Цагдаагийн газрын экологийн асуудал
хариуцсан эрүүгийн ахлах мөрдөгч, цагдаагийн хошууч

 (Б.Зам)

БОАЖГ-ын Усны нөөц ашиглалт, хамгаалалт, төрийн бус байгууллага,
судалгаа шинжилгээ хариуцсан мэргэжилтэн

 (Я.Батбилэг)

ХҮЛЭЭН ЗӨВШӨӨРСӨН:

"Нэхий таннери" ХХК-ийн ерөнхий захирал



2023 он

ДАРХАН-УУЛ АЙМГИЙН ДАРХАН СУМЫН ҮЙЛДВЭРИЙН
БҮСЭД БАЙРЛАХ “НЭХИЙ ТАННЕРИ” ХХК-ИЙН ХЭРЭГЖҮҮЛЖ
БУЙ “ДАРХАН АРЬС ШИР БОЛОВСРУУЛАХ ЦОГЦОЛБОР
ҮЙЛДВЭР” ТӨСЛИЙН 2023 ОНД ХЭРЭГЖҮҮЛСЭН БАЙГАЛЬ
ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН
ТАЙЛАН

Агуулга

1	ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА	3
1.1	Төслийн ерөнхий мэдээлэл.....	3
	Төслийн нэр:.....	3
	Төсөл хэрэгжүүлэгч:	3
	Төслийн талбайн байршил, хэрэгжиж буй орчны тойм зураг.....	3
1.2	Төсөл хэрэгжүүлэгчийн танилцуулга	3
1.3	Үйл ажиллагаа	4
1.4	Дэд бүтэц.....	4
1.5	Хог хаягдлын менежмент	4
1.5.1	Хатуу хог хаягдал.....	5
1.5.2	Химийн бодисын хог хаягдал	5
2	БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТУХАЙН ЖИЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ	6
2.1.1	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт	6
2.1.2	Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн төлөвлөгөө	13
2.1.3	Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт.....	14
2.1.4	Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөөний биелэлт	15
2.1.5	Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөний биелэлт	29
2.1.6	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн биелэлт	28
2.1.7	Удирдлага зохион байгуулалтын хүрээнд авч хэрэгжүүлэх арга хэмжээ	31

Хүснэгтийн жагсаалт

Хүснэгт 2-1. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө	6
Хүснэгт 2-2. Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн төлөвлөгөө	13
Хүснэгт 2-3. Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	15
Хүснэгт 2-4 Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө	29
Хүснэгт 2-5 Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр.....	28
Хүснэгт 2-6. Тоосонцрын хэмжилтийн үр дүн	30
Хүснэгт 2-7. Агаар бохирдуулагч бодисын хэмжилтүүд	30
Хүснэгт 2-8. Хаягдал бохир усны шинжилгээний хариу.....	30
Хүснэгт 2-9 Удирдлага зохион байгуулалтын хүрээнд авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө	31
Хүснэгт 2-10. Нэхий таннери ХХК-ийн үйлдвэрийн хог хаягдлын кодчилсон хүснэгт.....	28
Хүснэгт 2-11.	29

Зургийн хүснэгт

Зураг 1-1. Үйлдвэрийн талбайн байршил.....	3
Зураг 2-1. Түүхий эд материал, материалын үлдэгдэл цэвэрлэх явц	6

Зураг 2-2. Санамж тэмдэглэгээнүүд.....	9
Зураг 2-3. Усны тоолуурын баталгаажуулалтын гэрчилгээ №029662.....	9
Зураг 2-4. Зөвлөх үйлчилгээний гэрээ, Технологийн зөвлөмж	10
Зураг 2-5. Санал болгосон технологийн схем	11
Зураг 2-6. Химийн бодисын агуулахын тэмдэгжүүлэлт	12
Зураг 2-7. Санамж тэмдэг	12
Зураг 2-8. Хог хаягдлыг цэвэрлэгээ, ногоон байгууламж арчилгаа	13
Зураг 2-9. Хог хаягдлын тэмдэглэгээ.....	13
Зураг 2-10. Ногоон байгууламжийн арчилгаа, цэвэрлэгээ.....	14
Зураг 2-11. Үзлэг засвар үйлчилгээний явц.....	16
Зураг 2-12. Шинэчилсэн галын булан, хор	17
Зураг 2-13. Галын аюулгүй байдлын дүгнэлт	18
Зураг 2-14. Сургалтын гэрээ	21
Зураг 2-15. Сургалтын явц	23
Зураг 2-16. 2023 оны химийн бодисын агуулахад байгаа бодисууд, сав баглаа боодлын тооллогын бүртгэл.....	28
Зураг 2-17. Үйлдвэрийн ариутгалын явц	30
Зураг 2-18. Ариутгалын бодисын танилцуулга.....	31
Зураг 2-19. Энгийн хог хаягдлын тээвэрлэлтийн бүртгэл	32
Зураг 2-20. Энгийн хог хаягдлын гэрээ	33
Зураг 2-21. Хуванцар хаягдлыг хаях цэгт байршуулсан тэмдэглэгээнүүд.....	34
Зураг 2-22. Гадна талбайн цэвэрлэгээний явц.....	34
Зураг 2-23. Дархан-Ус суваг ХК-ийн гэрээ, төлбөрийн баримт	35
Зураг 2-24. Түүхий эд материалын үлдэгдлийг цэвэрлэгээ.....	35
Зураг 2-25. Цэцүүх трейд ХХК-д шилжүүлсэн аюултай хог хаягдлын бүртгэл	36
Зураг 2-26. Цэцүүх трейд ХХК-д хог хаягдлыг шилжүүлэх явц.....	37
Зураг 2-27. Агаараас сорьц авсан багаж.....	29
Зураг 2-28. Мониторингийн хэмжилт, дээжлэлтийн явц	29
Зураг 2-29. Хог хаягдлыг гэрээнүүд.....	29
Зураг 2-30. Аюултай хог хаягдал нийлүүлсэн бүртгэл.....	30
Зураг 2-31. Хог хаягдлын сургалтын явц, сургалтын материал	31
Зураг 2-32. Аудитын зөвлөмж, дүгнэлт	34
Зураг 2-33. Өгөөмж-Ирээдүй ХХК-иас мод худалдан авсан баримт.....	39
Зураг 2-34. Мод тарих явц /2023.10.30/	40
Зураг 2-35. Цахилгаан эрчим хүчээр хангах гэрээ.....	42
Зураг 2-36. Цэвэр усаар хангах, бохир усыг татан зайлуулах, цэвэрлэх гэрээ.....	43

1 ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА


1.1 ТӨСЛИЙН ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Төслийн нэр:	“Дархан арьс шир боловсруулах цогцолбор үйлдвэр”
Төсөл хэрэгжүүлэгч:	“Нэхий таннери” ХХК
	< Улсын бүртгэлийн дугаар: 1911024140
	< Регистрийн дугаар: 4280288
	< Хаяг: Дархан-Уул аймаг, Дархан сум, 13-р баг
	< Утас: +976 70378499

Төслийн талбайн байршил, хэрэгжиж буй орчны тойм зураг

Үйлдвэрийн байр нь Дархан-Уул аймгийн Дархан сумын 13-р баг, үйлдвэрийн бүсэд байрлах ба 8.9 га талбайтай, 21737 м² бүхий цутгамал бетон карказан барилгад үйл ажиллагаа явуулдаг.

Төслийн талбайн байршлын зургийг Зураг 1-1-т харууллаа.



Зураг 1-1. Үйлдвэрийн талбайн байршил

1.2 ТӨСӨЛ ХЭРЭГЖҮҮЛЭГЧИЙН ТАНИЛЦУУЛГА

Нэхий таннери ХХК нь Дархан Нэхий ХК-ийн охин компани бөгөөд арьс шир боловсруулах чиглэлээр үйл ажиллагаа явуулж байна. Тус компани нь түүхий эдээс эхлэн нойтон болон хуурай боловсруулалт хийж, хагас боловсруулсан арьс үйлдвэрлэн оёдлын охин компаниуд болон дотооддоо борлуулалт хийдэг. 2013 оноос механикийн боловсруулалт хийж бэлэн боловсруулсан арьс үйлдвэрлэн ажиллаж байна.

Нэхий боловсруулах үйлдвэр нь 2018 оны 11-р сараас Нэхий таннери ХХК болж бүтцийн өөрчлөлт хийж Евро стандартад нийцсэн байгальд ээлтэй, эко технологиор бүтээгдэхүүн үйлдвэрлэл явуулдаг бөгөөд экологийн шаардлага хангасан дээд зэргийн чанартай бүтээгдэхүүн болох

хонины нэхий, ямааны арьс, үхэр сарлагийн шир, ноос зэргийг боловсруулж зах зээлд худалдаалж байна.

2020 оноос Бид нийт хэрэглэгчдийнхээ сэтгэл ханамжийг тогтмол өндөр байлгах зорилгоор чанарын удирдлагын тогтолцооны ISO9001:2015 олон улсын стандартыг үйлдвэртээ нэвтрүүлсэн нь хэрэглэгч харилцагчдынхаа итгэлийг улам баталгаажуулж байгаагийн нэг илрэл болсон.

1.3 ҮЙЛ АЖИЛЛАГАА

Үйлдвэр нь өдөрт 1500 ширхэг хонины арьс, 500 ширхэг үхрийн шир боловсруулах хүчин чадалтай.

Нэхий таннери ХХК нь

! Нэхий боловсруулах үйлдвэр

! Шир савхины үйлдвэр гэсэн 2 үндсэн чиглэлээр үйлдвэрлэл явуулж байна.

Нэхий боловсруулах үйлдвэр нь түүхий эдийн 105-р тасаг, нойтон боловсруулах 110-р тасаг, гүйцээн боловсруулах 160, 180-р тасгаас бүрдэнэ.

Шир, савхи боловсруулах үйлдвэр нь түүхий эдийн 106-р тасаг, нойтон боловсруулах 111-р тасаг, гүйцээн боловсруулах 161, 181-р тасагтай. Мөн удирдлагын баг буюу ИТА, засвар үйлчилгээний баг буюу ТНА гэсэн бүтэцтэй нийт 100 гаруй ажилтантайгаар үйл ажиллагаа явуулж байна.

Нийт ажилтнуудын 18-24 насны ажилтан 10.8%, 25-30 нас 22.9%, 31-36 нас 33.7%, 37-43 нас 9.6%, 44-50 нас 13.3%, 51-55 нас 4.8%, 56-аас дээш насны ажилтан 4.8%-г тус тус эзэлж байна.

1.4 ДЭД БҮТЭЦ

Дулаан, эрчим хүчний хангамж

Үйлдвэрийн байгууламжийн дулаан, эрчим хүчний хангамжийг Дархан-Уул аймгийн Дархан сумын төвлөрсөн хангамжаас “Дархан дулааны сүлжээ” ТӨХК –тай гэрээ байгуулж ханган ажилладаг. Эрчим хүчний хувьд газраар дамжуулан 6 вольт хүчдэлтэй 2 талын тэжээлттэй шугамаар цахилгаан эрчим хүч авахаас гадна өөрийн дэд станцтай юм.

Усан хангамж

Нэхий таннери ХХК нь “Цэвэр усаар хангах, бохир усыг татан зайлуулах, цэвэрлэх аж ахуйн гэрээ”-г “Дархан-Ус суваг” ХК-тай байгуулан ус хангамжийг шийдэж ажилладаг.

1.5 ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТ

Хог хаягдлын тухай хууль нь 2012 оны 5-р сарын 17-ны өдөр батлагдсан бөгөөд 2017 он шинэчлэн баталсан. Хог хаягдлын тухай хуулиар хог хаягдлыг бууруулах, ангилах, цуглуулах, тээвэрлэх, хадгалах, дахин боловсруулах, эргүүлэн ашиглах, устгах, экспортлох болон хог хаягдлыг импортлох, хил дамжуулан тээвэрлэхийг хориглохтой холбогдсон харилцааг зохицуулахыг заасан. Мөн энэ хуулиар агаар мандал, усан орчны болон цацраг идэвхт хог хаягдлаас бусад хог хаягдалтай холбогдсон харилцааг зохицуулна. Хог хаягдлын тухай хуульд аж ахуйн нэгж байгууллага нь:

- I. Хог хаягдлыг дахин боловсруулах арга технологийг нэвтрүүлэх;
- II. Үйлдвэрлэл, үйлчилгээний төрлөөс хамаарч хог хаягдлыг төрөлжүүлж, хог хаягдал хадгалах түр цэгт ангилан хаях, хог хаягдлын талаарх мэдээллийг төрийн болон нутгийн захиргааны байгууллагад үнэн зөв мэдээлэх;
- III. Хог хаягдал цуглуулах, тээвэрлэх эрх авсан иргэн, аж ахуйн нэгж, байгууллагатай гэрээ байгуулан биелэлтийг хангаж ажиллах;
- IV. Аюултай хог хаягдлыг аюултай хог хаягдлын төвлөрсөн байгууламж, эсхүл тогтоосон тусгай цэгт устгах ёстой талаар заажээ.

1.5.1 Хатуу хог хаягдал

Ажилчдын ахуйн хэрэглээ болон үйлдвэрээс гарсан хатуу хог хаягдлыг зориулалтын хогийн савуудад хадгалан хог хаягдлын гэрээний дагуу нэгдсэн цэгт зайлуулдаг.

1.5.2 Химийн бодисын хог хаягдал

Хог хаягдлын тухай хуульд “аюултай хог хаягдал” гэж тэсрэмтгий, шатамхай, урвалын идэвхтэй, исэлдүүлэгч, агаар болон устай харилцан үйлчилж хортой хий ялгаруулдаг, халдвартай, идэмхий, хүн амьтанд богино болон удаан хугацаанд хортой нөлөөлөл үзүүлдэг, байгаль орчинд хортой шинж чанартай, устгасны дараа аюултай шинж чанартай ялгарал үүсгэдэг хог хаягдал гэж заасан байна.

Үйл ажиллагаанаас гарах химийн бодисын хог хаягдал /өнгөт металл тоног төхөөрөмжийн өнгөлөгч будгийн сав, баглаа боодол болон даралтат хоосон сав, г.м /-ыг Хог хаягдлын тухай хуулийн 23 дугаар зүйлд зааснаар Аюултай хог хаягдлыг эх үүсвэр дээр түр хадгалан, устгах, дахин ашиглах эрх бүхий мэргэжлийн байгууллагатай гэрээ байгуулан ажиллаж байна.

2 БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТУХАЙН ЖИЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

2.1.1 Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт

2.1.1.1 Агаарын чанарт үүсэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт

Хүснэгт 2-1. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө


№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ
	1	2	3
1	Түүхий эд, бүтээгдэхүүнийг муудсан үнэр орчинд тархах	Түүхий эд хүлээн авах ажилчид маск зүүх, муудсан үйлдвэрийн шаардлага хангахгүй түүхий эдийн ялган зориулалтын талбайд хаях	Түүхий эд буулгах талбай
2	Үйлдвэрийн дотоод агаарын чанар муудах, хэм нэмэгдэх	Үйлдвэрийн байранд дотоод орчныг сайжруулах, ажлын байрны үзлэг хийх, агааржуулалтыг тогтмол шалгах	Үйлдвэрийн дотор орчин
3	Зам дээрх тээврийн хөдөлгөөнөөс агаарт тоосжилт үүсэх	Түүхий эд материал тээвэрлэх ирэх тээврийн хэрэгслийг үйлдвэрийн талбайд тогтсон маршрутаар зорчуулах	Замууд
4	Ахуйн болон үйлдвэрийн үйл ажиллагаанаас үүсэх хог хаягдлыг ил задгай хаяснаас орчны бохирдол үүсэх	Үүссэн хог хаягдлыг тогтмол зайлуулах, хог хаягдал байршуулах талбайг цэвэрлэх, аюултай хог хаягдлыг тусгай эрх байгууллагад нийлүүлэх	Үйлдвэрийн талбай

Үйлдвэрлэлд ашиглах түүхий эд, материалыг зориулалтын бэлтгэсэн талбайд буулгаж, материалын үлдэгдэл зэргийг тогтмол цэвэрлэгээг хийж ажилласан. 2023 онд тухайн талбай бүрийг мал эмнэлгийн газраар ариутгаж цэвэрлэсэн. Үүссэн энгийн хог хаягдлыг Дархан хотын тохижилт үйлчилгээний газартай гэрээ байгуулж тээвэрлэх, устгах ажлыг зохион байгуулж ажилласан. Үүссэн хог хаягдлыг тогтмол зайлуулах, хог хаягдал байршуулах талбайг цэвэрлэх, аюултай хог хаягдлыг тусгай эрх байгууллагад шилжүүлэх ажлыг үр дүнг хог хаягдлын менежментийн хэсэгт дэлгэрэнгүй тусгав.



Зураг 2-1. Түүхий эд материал, материалын үлдэгдэл цэвэрлэх явц

Үйлдвэрийн байранд дотоод орчныг сайжруулах, ажлын байрны үзлэг хийх, агааржуулалтыг тогтмол шалгах ажлыг ХАБ болон Үйлдвэрийн технологич нар хамтран зохион байгуулдаг.



д/д	Илрүүлсэн зөрчил дутагдал	Оч, сар өдөр, цаг минут	Зөрчил илрүүлэгчийн гарын үсэг	Илрүүлсэн зөрчил дутагдлыг арилгах арга хэмжээ	Биелэлт
11/11/18A	<p>11-р тасал → & хэрэглэх хэрэгсэлгүй тэдэн их хайгуулагч & бүр түүнийг хийши Мэтэ сав & улам хөрөг 2023-4 сараас хойш байгалийн үйлдвэр шийдвэр; тооцог дарагдсан 2023.8.1</p> <p>11-р тасал & Ажлын байрны их урьд үзвэрлэх дутуу чухлийн шал угаах & Стехүн машинд арьс аллагданы үлдсэн арьс их угаагч & Савхинг түүрийн машинд арьс байгаа арьс хурдан хураагч</p>		ХАБ-а-н ажилтан А.Цолмолова Жтм	<p>Мөх тасгийг үйлдвэртэй мөхтөг болон болшиг ахлагч зөргөл ариуцаах татаар албан мөхдөг ариуцаах</p>	

Зураг 2-2. Үзлэгийн явц

Түүхий эд материал тээвэрлэх ирэх тээврийн хэрэгслийг үйлдвэрийн талбайд зорчуулахад харуул хамгаалалт болон ХАБ-ын ажилтнаас зааварчилгаа авч тогтсон маршрутаар зориулалтын талбайд буулгах ажлыг хийж гүйцэтгэдэг.



Зураг 2-3. Байршуулсан тэмдэглэгээ

2.1.1.2 Усан орчинд үүсэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ
1	Төслийн үйл ажиллагааны явцад ажилчдын унд ахуйд болон мод усалгаанд гүний ус ашигласнаар усны нөөц багасна	Усыг үр ашигтай хэрэглэх талаар ухуулга, сурталчилгаа хийж байх, мэдээллийн хуудсыг зохих газруудад байрлуулж шинэчилж байх	Үйлдвэрийн байр
		Усны нөөцийн хомсдолоос сэргийлэхийн тулд эх үүсвэр дээр тоолуурыг заасан хугацаанд баталгаажуулж байх, төлбөрийн тогтмол төлөх	Үйлдвэрийн байр
	Цэвэрлэх байгууламжийн үйл ажиллагаа алдагдах холбогдох стандартад нийцэхгүй байх /MNS 6561 : 2015/	Үйлдвэрийн Цэвэрлэх байгууламжийн сайжруулах технологийн судалгаа хийх, сайжруулах төсвийн үнийн санал авах	Үйлдвэрийн цэвэрлэх байгууламж

Үйлдвэрийн технологид ашиглах ус процессын дагуу 3 удаа эргүүлэн ашиглалт хийгдэж байна. Энэ нь удаа ашиглах цэвэр усны хэрэглээг багасгадаг. Харин ажилчдын ахуйд ашиглах усны хэрэглээг зөв зохистой хэмжээнд байлгах зорилгоор усны цорго, 00 өрөөнүүдэд зөвлөмж, анхааруулах санамж тэмдгүүдийг байршууллаа.




Зураг 2-4. Санамж тэмдэглэгээнүүд

Үйлдвэрт LXLG загварын 63.0 м³/ц хэмжих хязгаартай 2104000663-ын дугаартай халуун, хүйтэн усны тоолуурыг 2022 оны 09-р сарын 14-ны өдөр стандарт, хэмжил зүйн газраар баталгаажуулалт хийлгэж гэрчилгээг авсан. Усны тоолуур нь 022 дугаартай лацаар битүүмжилсэн бөгөөд 2024 оны 09-р сарын 14-ны өдөр хүртэл хүчинтэй байна. Мөн усны төлбөрийг тоолуурын заалтын дагуу сар бүр төлбөрийг тогтмол төлдөг.




Зураг 2-5. Усны тоолуурын баталгаажуулалтын гэрчилгээ №029662

Цэвэрлэх байгууламжийн шинжилгээний үр дүнгүүдээс үүдэн технологийн сайжруулах судалгаа хийх, төсөв өртгийн үнийн судалгааг хийх ажлыг зохион байгуулж ажиллаа. Үүний хүрээнд “Ус био инженеринг” ХХК-тай зөвлөх үйлчилгээний гэрээ байгуулж, үйлдвэрийн технологийн танилцуулга, цэвэрлэх байгууламжийн одоогийн процессыг танилцуулж үүнд тулгуурласан технологийн зөвлөмж, үнийн саналыг авсан.



Зураг 2-6. Зөвлөх үйлчилгээний гэрээ, Технологийн зөвлөмж

“Ус био инженеринг” ХХК нь үйлдвэрийн хүчин чадалд нийцүүлж 1000-1500м³/хон цэвэрлэх боломжтой технологийг санал болгосон. Технологийн схемийг доорх зургаар харууллаа.




Зураг 2-7. Санал болгосон технологийн схем

2.1.1.3 Хөрсөн орчин үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ
1	Олон салаа зам үүсгэснээр хөрсний эвдрэлд нэмэгдэх	Тээврийн хэрэгслийг зөвхөн 1 тогтсон замаар явуулах, олон салаа зам үүсгэхгүй байх, авто машин зогсох талбайг тэмдэгжүүлэх	Замууд
2	Химийн бодисын зохисгүй хэрэглээнээс хөрс бохирдох	Химийн бодисын эрсдэлийн үнэлгээ, зөвлөмжийг чандлан баримтлах, ХАЛМ-ын дагуу хадгалж ашиглах, тэмдэг тэмдэглэгээг байршуулах	Үйлдвэрийн химийн бодис хадгалах агуулах
3	Шатах тослох, материал, нефтийн бүтээгдэхүүн асгарч хөрсөн бүрхэвч бохирдох	Санамж тэмдэг байршуулах	Үйлдвэрийн талбай


Үйлдвэрийн талбайд нэвтрэх тээврийн хэрэгслийн жолоочид хамгаалалтын алба болон ХАБ-н ажилтан зааварчилгаа өгч ачаа, материал, түүхий эдийн зориулалтын талбай бүрт буулгаж ажиллаж байна. Мөн ажилчдын тээврийн хэрэгсэл үйлдвэрийн гадна талд зориулалтын хатуу хучилттай зогсоолд байршуулдаг. Химийн бодисын хадгалах агуулах нь холбогдох стандарт нийцсэн бөгөөд химийн бодис ачих, буулгах талбай нь бүрэн хатуу хучилттай байна. Иймд олон салаа зам үүсэх, хөрсний эвдрэл, бохирдол үүсэх нөлөөлөл бага юм.

Химийн бодисын агуулахад стандартын дагуу тэмдэг тэмдэгжүүлэлтийг бүрэн байршуулсан.



Зураг 2-8. Химийн бодисын агуулахын тэмдэгжүүлэлт

Мөн авто машин зогсох талбайд шатах тослох, материал, нефтийн бүтээгдэхүүн асгаруулахаас сэргийлж санамж тэмдгийг байршуулсан.



Зураг 2-9. Санамж тэмдэг

2.1.1.4 Ургамлан нөмрөг, амьтны аймагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний биелэлт

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ
1	Ажилчдын хатуу шингэн хог хаягдлын улмаас хөрс бохирдох	Хог хаягдлыг ангилан ялгаж, Дархан-Уул аймгийн Дархан сумын нэгдсэн хогийн цэгт тогтмол зайлуулж байх. Хог хаягдлыг шатааж устгахыг хатуу хориглох.	Үйлдвэрийн талбай орчмын хөрс
		Зориулалтын цэгээс гадагш элдэв хог хаягдал хаяхгүй, газрын төрх, хөрсийг эвдэхгүй, хөндөхгүй байх арга хэмжээг хэвшүүлэх, самбар пайз байрлуулах	
2	Ногоон байгууламжийн арчилгаа муудсанаар орчны үзэмж муудах	Үйлдвэрийн талбайн ногоон байгууламжийг сайжруулах, арчилж тордох	Ногоон байгууламжийн талбай

Үйлдвэрээс үүсэх хог хаягдлыг зориулалтын талбайд болон саванд хаяж тээвэрлэлт, тогтмол хийж гүйцэтгэсэн. Мөн ногоон байгууламжийг дулааны улиралд арчилж тордох ажлыг хийж гүйцэтгэлээ.



Зураг 2-10. Хог хаягдлыг цэвэрлэгээ, ногоон байгууламж арчилгаа

Хог хаягдал ил задгай хаяхаас сэргийлж доорх тэмдгүүдийг үйлдвэрийн гадна болон дотор нийт 6 газар байршууллаа.



Зураг 2-11. Хог хаягдлын тэмдэглэгээ

2.1.2 Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн төлөвлөгөө

Хүснэгт 2-2. Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн төлөвлөгөө

Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн зорилт	Арга хэмжээ	Арга хэмжээний цар хэмжээ	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, төг	Нийт зардал төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	2	3	4	5	6	7	8	9
Хөрсний үржил шимтэй байдлыг хадгалах, агаарт тоосжилт бохирдол үүсэхээс урьдчилан сэргийлэх	Ногоон байгууламжийн талбайг арчилж тордох	Үйлдвэрийн ногоон байгууламжийн талбайд /4,129.75 м ² /	м ²	4,129.75	-	2,000,000	6,7,8,9-р саруудад	Байгаль орчныг хамгаалах тухай хууль Байгаль орчинд нөлөөлөх байдлыг тухай хууль Газрын тухай хууль MNS 5914:2008 Байгаль орчин. Эвдэрсэн газрын нөхөн сэргээлт. Нэр томьёо, тодорхойлолт

Үйлдвэрийн талбай дах ногоон байгууламжийг тордох цэвэрлэх ажлыг цэвэрлэгээний ажилчид хариуцаж ажилладаг бөгөөд дулааны улиралд сар бүр тогтмол цэвэрлэгээ хийж ажилласан. Энэ жилд унасан хур тунадасны хэмжээ их байсан тул усалгаажилт шаардлагагүй гэж үзэн хийгээгүй болно.



Зураг 2-12. Ногоон байгууламжийн арчилгаа, цэвэрлэгээ

2.1.3 Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт

Төсөл хэрэгжих талбай орчимд ямар нэгэн археологи, палеонтологийн олдвор бүртгэгдээгүй болно.

2.1.4 Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөөний биелэлт

Хүснэгт 2-3. Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө

Болзошгүй аюул, осол, сөрөг нөлөө	Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ
1	2
Аянга цахилгаан	Үйлдвэрт ашиглагдаж буй тоног төхөөрөмжийн үзлэгийг хуваарийн дагуу хийх, аянга газардуулагчийг шалгах, шаардлагатай тохиолдолд нэмж суурьшуулах
Гал түймэр	Гал унтраах багаж хэрэгслийн иж бүрдлийг бүрдүүлж бэлэн байлгах. Гал түймрийн үед авч хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг гарган ажиллагсдад сургалт зохион байгуулах. Галын аюулын талаар анхааруулга самбарыг эзэмшлийн объект бүрд онцлогийг нь тусган тавих зэрэг арга хэмжээг авах шаардлагатай. Үйлдвэрийн барилгын галын аюулгүй байдлын дүгнэлтийг гаргуулах
Үйлдвэрийн үйл ажиллагаанаас гэнэтийн болзошгүй байдлаар үйлдвэрт осол аваар гарах, тоног төхөөрөмж эвдрэх, ажилчид цахилгааны хүчдэлд цохиулах, түлэгдэх	Үйлдвэрийн ажилчдыг хөдөлмөр хамгааллын хувцас хэрэгслээр хангах ХАБЭА-н шинэчлэгдсэн дүрэм журмыг таниулах сурталчлах, сургалт өгөх
Химийн бодисын асгаралт	Химийн бодис асгарах, алдагдах үед ашиглах нэг бүрийн хамгаалах хэрэгсэл, асгаралт болсон тохиолдолд саармагжуулах хэрэгслийг байрлуулах. /элс хоосон сав, бортого, бортого онгойлгогч, наалддаг шошго, металл юүлүүр, хүрз, хогийн шүүр, хориглох тэмдэг болон түүз зэрэг
Химийн бодисын нөлөөнд өртөх	Химийн бодистой зөв харьцах, хадгалах, ашиглах талаар агуулахын ажилчдад сургалт зохион байгуулах
Химийн бодисын агуулахын аюулгүй байдал алдагдах	Химийн бодисын агуулахад тогтмол хугацааны давтамжтайгаар хяналт хийж, тэмдэглэл хөтлөх <ul style="list-style-type: none"> - Агааржуулалтын системийн бүрэн бүтэн байдлыг 14 хоногт 1 удаа шалгах - Химийн бодис сав баглаа боодлыг 14 хоногт 1 удаа шалгах - Химийн бодисын тавиурын бүрэн бүтэн байдлыг шалгах

3 Аянга цахилгаан

Үйлдвэрийн дарга, техникчид, ХАБ-ын ажилчид Үйлдвэрт ашиглагдаж буй тоног төхөөрөмжийн үзлэгийг хуваарийн дагуу хийж, засвар үйлчилгээг гүйцэтгэсэн.





Зураг 2-13. Үзлэг засвар үйлчилгээний явц

3 Гал түймэр

2023 онд үйлдвэрийн барилга дах нийт галын булан, галын хор зэргийг нэгдсэн байдлаар шинэчилж байршуулсан. Мөн гал гарсан үед аврах гарцын схем, тухайн авах арга хэмжээний самбаруудыг шинэчилсэн. Үйлдвэрийн ХАБ-н ажилтан шинээр ажилд орсон ажилтан бүрд гал түймрийн үед авч хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг танилцуулж, сургалт орсон.



Зураг 2-14. Шинэчилсэн галын булан, хор

Үйлдвэрийн барилгын галын аюулгүй байдлын дүгнэлтийг 2023 онд дуусаж байсан учир Дархан-Уул аймгийн Онцгой байдлын газарт хүсэлт өгч, Гал түймрийн улсын хяналтын байцаагч А/д цолтой Н. Баасанхүү шалгалт хийж дүгнэлт гаргасан (Зураг 2-15).

		Онцгой байлын ерөнхий газрын даргын 2021 оны 07 дугаар сарын 07-ны өдрийн А/154 дугаар тушаалын 2 дугаар хавсралт
<h1>ГАЛЫН АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ДҮГНЭЛТ</h1>		
Дугаар 0010020		
Аж ахуйн нэгж, байгууллагын нэр:		Нэхий таннери ХХК
Хаяг:		Дархан сум 13-р баг Үйлдвэрийн район
Ажлын байрны зориулалт, үйл ажиллагааны чиглэл:		
Түүхий эд боловсруулах үйлдвэр		
Барилга байгууламжид гал унтраах тоног төхөөрөмж, / гал унтраах автомат болон дохиоллын систем, утаа зайлуулах сүстем, усан хангамж /анхан шатны багаж хэрэгсэл, бодис материал зэргийг байрдуулан ашиглахад энэхүү дүгнэлтийг олгоно. /Галын аюулгүй байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.3/		
Олгосон:		2023 он 03 сар 31 өдөр
Хүчинтэй хугацаа:		2025 он 03 сар 30 өдөр хүртэл
Дүгнэлт олгосон:		
Дархан-Уул аймаг, нийслэлийн Онцгой байдлын газар /хэлтсийн/ Хурандаа	цолтой	С.Пүрэвсамдан
Дүгнэлт гаргаван:		
Дархан-Уул аймаг, нийслэлийн Онцгой байдлын газар /хэлтсийн/ Гал түймрийн улсын хяналтын байцаагч:	А/д цолтой	Н.Баасанхүү
/гэмдэг дарга/		

Зураг 2-15. Галын аюулгүй байдлын дүгнэлт

3 ХАБЭА

Үйлдвэрийн ХАБ хариуцсан мэргэжилтэн үйлдвэрлэлтийн явцад нийт ажилчдадаа өдөр тутмын зааварчилгаа, хуваарь шалгалт зэргийг тогтмол хийж ажиллаж байсан. ХАБЭА-н сургалтыг Ойгон нөмрөг ТББ-тай 2023 оны 02-р сарын 17 өдөр байгууллагын нийт ажилчдад ХЭБЭА-н мэдлэг олгох сургалтыг зохион байгуулах, зөвлөгөө өгч, сургалтын ач холбогдлыг таниулах гэрээ байгуулж ажилласан. Хөдөлмөрийн, Нийгмийн хамгааллын Сайдын 2019 оны А/370 тоот тушаалаар батлагдсан журам болон сургалтын хөтөлбөрийг дагуу сургалтын хөтөлбөр, цагийн хуваарь, сургалтын агуулга зэргийг боловсруулан, баталж үйл ажиллагааг зохион байгуулсан. Сургалтын хүрээнд нийт 5 төрлийн сургалтыг багтаасан. Үүнд:

1. Зөвлөх туслах үйлчилгээ
2. Нийт ажилтны сургалт
3. Ажил олгогчийн сургалт
4. Өндөр эрсдэлтэй ажлын байрны сургалт
5. Шинэ ажилтны сургалт

БАТЛАВ: “НЭХИЙ ТАННЕРИ” ХХК-ИЙН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

..... /Я.АЗЗАЯА/
ХХК



БАТЛАВ: “ОЙГОН НӨМРӨГ” ТББ-ЫН
ЗАХИРАЛ

..... /С.Цогдуряа/
/С.ЦОГБАДРАХ/



ХАМТАРЧ АЖИЛЛАХ ГЭРЭЭ

2023 он 02 сарын 17 өдөр

№ 23/02

Дархан уул аймаг

Энэхүү гэрээг нэг талаас “Нэхий Таннери” ХХК /цаашид “Захиалагч” гэх/
РД:4280288, нөгөө талаас “Ойгон нөмрөг” ТББ /цаашид “Гүйцэтгэгч” гэх/, РД:8271275
түүнийг төлөөлж менежер М.Төмөрхуяг нар нь дараах нөхцөлөөр харилцан тохиролцож
энэхүү гэрээг байгуулав.

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

- 1.1 Энэхүү гэрээгээр Сургалт захиалагч байгууллагын нийт ажилтанд ХАБЭА-н мэдлэг олгох сургалтыг зохион байгуулах, Зөвлөгөө болон харилцан ашигтай хамтран ажиллахтай холбогдсон талуудын хооронд үүсэх эрх зүйн харилцааг зохицуулна.
- 1.2 Гүйцэтгэгч тал нь Хөдөлмөрийн, Нийгмийн хамгааллын Сайддын 2019 оны А/370 тоот тушаалаар батлагдсан журам болон сургалтын хөтөлбөрийг дагуу сургалтын хөтөлбөр, цагийн хуваарь, сургалтын агуулга зэргийг боловсруулан, батлаж сургалтын үйл ажиллагааг зохион байгуулах, гэрээний хугацаанд захиалагч талийн нийт ажилтан болон ХАБЭА-н ажилтанд зөвлөн туслах ажлыг зохион байгуулна
- 1.3 Захиалагч байгууллагын ХАБЭА-н ажилтан болон Сургалтын мэргэжилтэн нь нийт ажилтнуудад сургалтын тухай бүрэн ойлголт өгч сургалтын ач холбогдолыг таниулан сургалтын байгууллагатай хамтарч ажиллана.
- 1.4 Захиалагч тал нь сургалт зохион байгуулах зөвлөн туслах явцад Гүйцэтгэгчийн багш ажилтны ажиллах нөхцөл бололцоогоор бүрэн хангаж шаардлагатай дэмжлэгийг үзүүлнэ.
- 1.5 Гүйцэтгэгч байгууллага нь “Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн сургалт явуулах болон шалгалт авах журам”-ын 4.1, 4.2-т заасан шаардлагыг хангасан байх бөгөөд нотлох баримт бичиг нь гэрээний салшгүй нэг хэсэг байж, гэрээний нэгэн адил хүчин төгөлдөр эрх зүйн баримт бичиг байна.
- 1.6 Хоёр тал тохиролцож гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулж болно. Нэмэлт өөрчлөлтийг бичгээр тохиролцож гарын үсэг зурж тамга тэмдэг дарснаар гэрээнд хавсаргана.


Хамтран ажиллах гэрээний хавсралт №1



ХАБЭА-н Зөвлөн туслах үйлчилгээ, сургалтын төрөл, сургалтын төлбөр

№	Сургалтын төрөл	Цаг	Хүний тоо	Сургалтын төлбөр		Сертификат
				1 хүний	Нийт	
1	Зөвлөн туслах үйлчилгээ	Гэрээний хугацаанд	3	-	-	-
2	Нийт ажилтны сургалт	12	102	25 000	2 550 000	Байгууллагад 1 ширхэг
3	Ажил олгогчийн сургалт	8	4	120 000	480 000	Тус бүр 1
4	Өндөр эрсдэлтэй ажлын байрны сургалт	10	1	120 000	1 200 000	Тус бүр 1
5	Шинэ ажилтны сургалт	8	1	25 000	Сар бүрийн 25-ны дотор	-
	Нийт дүн				4 230 000	

Зураг 2-16.Сургалтын гэрээ





Зураг 2-17. Сургалтын явц

3 Химийн бодис


Нэхий таннери ХХК нь үйлдвэрт ашиглагдаж байгаа химийн бодисуудыг хадгалах химийн бодисын агуулах нь MNS 6458:2014 стандартад нийцэн бөгөөд химийн бодисуудын хадгалалтын нөхцөлөөс шалтгаалан аюулгүй байдлын үүднээс ангилан хадгалж байна.


Химийн бодис асгарах, алдагдах үед ашиглах үеийн багаж хэрэгсэл, материалыг тогтсон байршил байрлуулж бүрэн байдлыг улирал бүр шалгаж ажиллаа.

Түүнчлэн химийн бодисын агуулахд “Spill Smart” асгарлын хэрэгслийн иж бүрдэл, галын аюулгүй байдлын самбар, бүртгэл хяналтын хуудаснуудыг байрлуулсан байна. Асгарлын иж бүрэн хэрэгсэл зургийг харуулав.



Зураг 2-18. Асгаралтын иж бүрдэл





2023оны байдлаар химийн бодисын агуулахын үлдэгдэл болон хаягдал сав, баглаа боодлын бүртгэлийн доорх зурагт оруулаа.


“Нэхий таннери” ХХК-ийн хэрэгжүүлж буй “Дархан арьс шир боловсруулах цогцолбор үйлдвэр” төслийн
2023 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайлан


1. Онцгой хортой химийн бодисын бүртгэл-2023

Нэхий Таннери ХХК-н сөрөнхий захирлын 2023 оны
..... тоотын хавсралт

МАЯГТ ХБ1-1

Д/д	Бодисын нэр томъёо	Уялдуулсан системын код	Хаана хадгалагч	ХАЛМ нэгж зэх	Эхний үлдэгдэл, кг	Хүлээн авсан нийт хэмжээ, кг	Тухайн онд хэрэглэсэн хэмжээ, кг	Бүтэд, кг	Усанд хавсан хэмжээ, кг	Хөрсөнд хавсан хэмжээ, кг	Хоргүйж үүлсэн устгасан бодис, кг	Тухайн оны үлдэгдэл, кг
1	Бактерицид /Bactericide, preservative agent/	3824.90900	Дотор агуулахад	Тийм	2,744.00	-	-	2,744.00	-	-	-	2,744.00
2	Аммонийн усан уусмал /Ammonium hydroxide/	2825.90500		Тийм	5,329.61	-	4,552.4	777.24	-	-	-	777.24
3	Хүхрийн хүчлэл /Sulfuric acid/	2807.00001	Гадна агуулахад	Тийм	624.45	11,509.9	10,805.4	1,328.00	-	-	-	1,328.00
4	Хромын сульфат /Chromium sulfate/	2833.23000		Тийм	-	100,000.0	63,503.2	36,496.76	-	-	-	36,496.76
5	Хүхэрт натри /Sodium sulfide/	2830.10000		Тийм	29,980.00	58,500.0	72,023.4	16,456.60	-	-	-	16,456.60
Нийт					38,678.1	170,009.9	150,884.5	57,802.6	-	-	-	57,802.6

Тайлан гаргасан:  /А. Байсгалан/

Тайлан шалгасан:  /Б. Дамбасүрэн/


2. Хортой химийн бодисын бүртгэл-2023

Нэхий Таннери ХХК-н сөрөнхий захирлын
2023 оны тоотын хавсралт

МАЯГТ ХБ1-2

Д/д	Бодисын нэр томъёо	Уялдуулсан системын код	Хаана хадгалагч	ХАЛМ нэгж зэх	Эхний үлдэгдэл, кг	Хүлээн авсан нийт хэмжээ, кг	Тухайн онд хэрэглэсэн хэмжээ, кг	Бүтэд, кг	Усанд хавсан хэмжээ, кг	Хөрсөнд хавсан хэмжээ, кг	Хоргүйж үүлсэн устгасан бодис, кг	Тухайн оны үлдэгдэл, кг
1	Дэвтээгч /Wetting agent/	3402.1200	Дотор агуулахад	Тийм	505.6	-	-	505.61	-	-	-	505.61
2	Сульфат аммоний /Ammonium sulfate/	3102.2100		Тийм	544.5	56,900.0	51,108.0	6,336.50	-	-	-	6,336.50
3	Зөөлрүүлэгч /Acid, pancreatic bating enzyme/	3507.9010		Тийм	1,608.5	1,026.8	969.6	1,665.60	-	-	-	1,665.60
4	Илээгэгч /Tanning agent/	3202.9020		Тийм	23,575.8	27,000.0	13,159.0	37,416.87	-	-	-	37,416.87
5	Дүүргэгч /Resins, Polyomere fillers/	3915.9010		Тийм	2,152.8	27,900.0	25,821.8	4,231.00	-	-	-	4,231.00
6	Угаагч саван /Washing, Soaking agent/	3402.9000		Тийм	553.0	29,550.0	17,222.5	12,880.51	-	-	-	12,880.51
7	Үс угаагч шохойлогийн боис			Тийм	5,366.5	-	-	5,366.50	-	-	-	5,366.50
8	Шохой ариулагч боис /Decalim plus/	3402.9099		Тийм	1,354.2	3,000.0	2,234.2	2,120.00	-	-	-	2,120.00
9	Мөөгөнцөрийн эсрэг боис /Antimuff/			Тийм	729.3	-	51.9	677.40	-	-	-	677.40
Нийт					36,390.2	145,376.8	110,567.0	71,200.0	-	-	-	71,200.0

Тайлан гаргасан:  /А. Байсгалан/

Тайлан шалгасан:  /Б. Дамбасүрэн/

“Нэхий таннери” ХХК-ийн хэрэгжүүлж буй “Дархан арьс шир боловсруулах цогцолбор үйлдвэр” төслийн
2023 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайлан

3. Бага зэргийн хортой химийн бодисын бүртгэл-2023

Нэхий Таннери ХХК-н ерөнхий захирлын 2023
оны тоотын хавсралт

МАЯГТ ХБ1-3

Д/д	Бодисын нэр томъёо	Уялдуулсан сентемын код	Хаана халгалдаг	ХАЛМ нээсэн эсэх	Эхний үлдэгдэл, кг	Хүлээн авсан нийт хэмжээ, кг	Тухайн онд хэрэглэсэн хэмжээ, кг	Бүтл, кг	Усанд хаясан хэмжээ, кг	Хорсонд хаясан хэмжээ, кг	Хоргүйжүүлсэн устгасан бодис, кг	Тухайн оны үлдэгдэл, кг	
1	Сууруулагч /Bating agent/	3809.9390	Дотор агуулахад	Тийм	645.1	-	-	645.08	-	-	-	645.1	
2	Натрийн бикарбонат /Sodium bicarbonate/	2836.3000		Тийм	6,849.5	8,000.0	6,137.9	8,711.61	-	-	-	-	8,711.6
3	Натрийн карбонат /Sodium Carbonate/	2836.2020		Тийм	6,529.9	-	6,529.9	-	-	-	-	-	-
4	Формат Натри /Sodium formate/	2915.1210		Тийм	4,722.6	9,000.0	7,932.3	5,790.37	-	-	-	-	5,790.4
5	Тос /Natural, synthetic fat/oil/	3403.1100		Тийм	16,470.6	18,413.7	19,327.3	15,557.03	-	-	-	-	15,557.0
6	Ургамлын идээлэгч /Tara, Mimosal/	3201.0000		Тийм	-	3,900.0	3,365.6	534.45	-	-	-	-	534.5
7	Хөрсний булаг /Leather dyestuff/	3204.1200		Тийм	3,983.7	7,643.0	7,298.2	4,328.50	-	-	-	-	4,328.5
8	Үсний булаг /Oxidation, tone/	3204.1200		Тийм	118.1	500.0	228.1	390.78	-	-	-	-	390.8
9	Холбогч резин /Polyetherane resin/	3905.5091		Тийм	10,275.6	1,050.0	6,668.6	4,656.92	-	-	-	-	4,656.9
10	Акрилик холбогч резин /Acrylic resin/	3906.9090		Тийм	2,337.3	-	-	2,337.30	-	-	-	-	2,337.3
11	Уургийн холбогч резин / Protein resin/	3906.9090		Тийм	614.0	-	-	614.00	-	-	-	-	614.0
12	Дүүргэгч болон барьц сайжруулагч /fillers/	3809.9301		Тийм	1,009.5	1,000.0	1,839.6	169.83	-	-	-	-	169.8
13	Бэхжүүлэгч /Lacquers/	3809.9300		Тийм	1,752.9	12,000.0	2,996.3	10,756.65	-	-	-	-	10,756.7
14	Будаг пигмент /Pigments/	3210.0900		Тийм	5,125.6	1,650.0	1,703.0	5,072.60	-	-	-	-	5,072.6
15	Гэмтэл даргач /Filler Waxes/	3809.9300		Тийм	4,786.8	-	4,617.0	169.83	-	-	-	-	169.8
16	Перхлорэтилен /Perchloroethylene/	2903.2300		Тийм	7,800.0	49,200.0	30,300.0	26,700.00	-	-	-	-	26,700.0
	Нийт				73,021.9	112,356.7	98,943.6	86,434.9	-	-	-	86,434.9	

Тайлан гаргасан: /А. Баясгалан/

Тайлан шалтасан: /Б. Дашдэрэн /

4. Онцгой шатамхай химийн бодисын бүртгэл-2023

Нэхий Таннери ХХК-н ерөнхий захирлын 2023
оны тоотын хавсралт

МАЯГТ ХБ1-4


Д/д	Бодисын нэр томъёо	Уялдуулсан сентемын код	Хаана халгалдаг	ХАЛМ нээсэн эсэх	Эхний үлдэгдэл, кг	Хүлээн авсан нийт хэмжээ, кг	Тухайн онд хэрэглэсэн хэмжээ, кг	Бүтл, кг	Усанд хаясан хэмжээ, кг	Хорсонд хаясан хэмжээ, кг	Хоргүйжүүлсэн устгасан бодис, кг	Тухайн оны үлдэгдэл, кг
1	Тос авагч /Degreasing agent/	3402.0000	Дотор агуулахад	Тийм	9,201.1	18,413.7	23,218.1	4,396.7	-	-	-	4,396.7
2	Шаргоослохны хүчил /Formic acid/	2915.1100		Тийм	4,102.0	29,540.0	26,033.8	7,608.2	-	-	-	-
	Нийт				13,303.1	47,953.7	49,252.0	12,004.9	-	-	-	12,004.9


Тайлан гаргасан: /А. Баясгалан/

Тайлан шалтасан: /Б. Дашдэрэн /

Химийн материалын сав баглаа боодлын тооллого 2023.11.10

№	Аж ахуйн нэгжийн нэр	Хог хаягдлын төрөл хэмжээ		Байгаль орчинд нөлөөлөх үнэлгээтэй эсэх	Ажлын байранд	Тусгайлан өрөөнд	Зориулалтын агуулахад	Химийн хорт болон аюултай бодисын агуулахын дүгнэлтэй эсэх	Тээвэрлэлт						
		Тусгай зөвшөөрлийн №	Нэр төрөл						Хэмжээ	1 жилд хэдэн удаа тээвэрлэх	Хог хаягдлын хэмжээ	Тээврийн	Тайлбар		
1	Нэхий Таннери ХХК	/0000883/	1тонны сав	165	+	1		165	+	2	11		166		
			200л төмөр сав	117	+	0		117	+	0	5		117		
			120л хуванцар сав	499	+	81		499	+	2	60		580		
			50л 60л хуванцар сав	214	+	3		214	+	2	35		217		
			30л хуванцар сав	192	+	84		192	+	2	215		276		
			25л хуванцар сав	670	+	2		670	+	2	497		672		
			Дугуй цаасан сав	410	+	9		410	+	0	5		419		
			Нийт	2267		180		2267					2447		

Тайлан шалгасан ХАХГЗ:  /Б. Дашцэрэн /

Тайлан гаргасан МНА:  / А. Баясгалан /

Зураг 2-19. 2023 оны химийн бодисын агуулахад байгаа бодисууд, сав баглаа боодлын тооллогын бүртгэл

2.1.5 Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөний биелэлт


Нэхий таннери ХХК нь үйл ажиллагаанаасаа гарч буй хог хаягдлын хэмжээг багасгах, аль болох бага хог хаягдал үүсгэх, түүнийг дахин ашиглах болон дахин боловсруулах замаар гарсан хог хаягдлын хэмжээг бууруулах, үлдсэн хог хаягдлыг хүрээлэн буй орчинд аюулгүй байдлаар устгах зарчмыг баримтлан ажиллана.

Хүснэгт 2-4 Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө

№	Хог хаягдлын ангилал	Сөрөг нөлөөллийг ‘арилгах, бууруулах’ арга хэмжээ
	1	2
1.	Ахуйн ‘Энгийн	Хог хаягдал түр хадгалах талбай орчимд тогтмол ариутгал, цэвэрлэгээ хийх Хог хаягдлыг ангилан ялгаж, тохижилт үйлчилгээний газартай гэрээ байгуулан төслийн талбайгаас тогтмол зөөвөрлүүлэх Ажилчдад хог хаягдлаа бууруулах, ангилан ялгах талаарх мэдээллийг самбарт байршуулах Төслийн талбай орчмын эргэн тойронд 50 м зайд цэвэрлэгээ хийх
2.	Үйлдвэрийн	Цэвэрлэх байгууламжийн хаягдал ус болон лагыг тогтмол холбогдох байгууллагад нийлүүлэх Түүхий эдийг зориулалтын бус талбайд буулгахыг хориглох, буулгасан талбайд тогтмол цэвэрлэх
3	Аюултай	Үйл ажиллагаанаас гарч буй химийн бодисын сав баглаа боодлыг журмын дагуу түр хадгалан, тусгай зөвшөөрөл бүхий байгууллагад өгөх

3 Энгийн хог хаягдал




2023 онд хог хаягдлын менежментийн төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу үйлдвэрийн нийт байгууламж, тоног төхөөрөмжүүдэд Мал эмнэлгийн ерөнхий газартай гэрээ байгуулж 09-р сард мэргэжлийн баг бүрэлдэхүүнтэй, зориулалтын бодисуудыг ашиглан ариутгалыг хийж гүйцэтгүүлсэн.






Зураг 2-20. Үйлдвэрийн ариутгалын явц


Ариутгалд экотрин-10%, суперкилл зэрэг бодисуудыг ашигласан бөгөөд малын гаралтай халдвар, хорхой, шалз, шимэгч зэргийг устгах зориулалттай. Ариутгал хийх явцад тухайн бодисуудын хүчинтэй хугацааг шалгаж зориулалтын шүршигч машинаар шүршиж ариутгасан.



Зураг 2-21. Ариутгалын бодисын танилцуулга

Үйлдвэрийн энгийн хог хаягдлыг “Дархан хотын тохижилт үйлчилгээний газар”-тай хог хаягдал ачиж, тээвэрлэх, хамтран ажиллах гэрээ байгуулж ажилладаг. Жил бүрийн ажлын төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу гэрээг 2024 оны 09-р сарын 26-ны өдрийг хүртэл 1 жилээр сунган хамтран ажиллана (Зураг 2-23). Үүссэн энгийн хог хаягдлын хэмжээг тээвэрлэсэн жолооч бүртэй тооцооны хуудас үйлдэн бүртгэж байна (Зураг 2-22).

БАТЛАВ:
“ДАРХАН ХОТЫН ТОХИЖИЛТ
ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ГАЗАР”-ЫН ДАРГА

З.ЭРДЭНЭБАТ

БАТЛАВ:
“Нэхий Таннери” ХХК
-Н ЗАХИРАЛ ДАРГА/

Г. Ж. Ж. Ж.

ХОГ ХАЯГДАЛ АЧИЖ, ТЭЭВЭРЛЭХ, ХАМТРАА АЖИЛЛАХ ГЭРЭЭ

2023 оны 09 сар 27 өдөр №..... Дархан-Уул аймаг

Иргэн, ААН байгууллагын нэр	Нэхий Таннери	
Регистерийн дугаар	4280288	
Үйл ажиллагааны чиглэл	Нэхий боловсруулах	
Иргэн, ААНБ-ын хаяг	Увс сумын байр	
ААНБ-ын холбогдох утас	89113180 88022207 99951414	
Данс	Хаан банк 5108367520	
Хог хаягдлын үйлчилгээний хураамжийн төрөл	Сардтөгрөг	Рейсийн тоогоор 1 рейс 1.11500 Төгрөг
Гэрээний хугацаа	20.23 оны 09-р сарын 27-ны өдрөөс 20.24 оны 09-р сарын 26-ны өдөр хүртэл	
Гэрээний сунгалт	20..... оны-р сарынны өдрөөс 20..... оны-р сарынны өдөр хүртэл	

Гүйцэтгэгч талаас “Дархан Хотын Тохижилт Үйлчилгээний Газар” ОНӨААТҮГ-ыг төлөөлж Ахлах байцаагч Баянхишиг овогтой Отгонтуяа Нөгөө талаасовогтой...../цаашид захиалагч тал гэх/ нар нь “Монгол Улсын Хог Хаягдлын тухай хууль”, “Зөрчлийн тухай хууль” эдгээртэй нийцүүлэн гаргасан бусад эрх зүйн актуудыг үндэслэн харилцан тохиролцож энэхүү гэрээг байгуулав.

Энэхүү гэрээний зорилго нь гүйцэтгэгч тал нь ААНБ-аас гарч байгаа ахуйн болон аюултай, эрсдэлтэй хог хаягдлыг гэрээнд заасан хугацаанд ачиж тээвэрлэх түрж булж устгах, захиалагч тал нь гэрээнд заасан хугацаанд төлбөрийг төлөх болон байгууллага хоорондын ажлын уялдааг сайжруулж хариуцлагыг дээшлүүлэхэд оршино.

Хоёр. Гүйцэтгэгч талын эрх үүрэг

- 2.1 Захиалагч талаас гэрээгээр хүлэсэн үүргээ биелүүлэхийг шаардах эрхтэй
- 2.2 Хог хаягдал тээвэрлэсний хөлсийг гэрээнд заасан хугацаанд төлж барагдуулахыг шаардах эрхтэй
- 2.3 Хог тээврийн машин орж ачих боломжгүй байршилд байгаа, тогтоосон цэгт төвлөрүүлээгүй, хог тээврийн хураамжаа тайлант хугацаанд төлөөгүй, хуримтлагдсан өртэй ААНБ-ын хог хаягдлыг ачиж тээвэрлэхгүй байх эрхтэй.
- 2.4 Хог хаягдлын тухай хууль тогтоомжуудыг үндэслэн хог хаягдлаа ачиж тээвэрлүүлэх, зориулалтын зөвшөөрөгдсөн цэгт хаяхыг шаардах эрхтэй
- 2.5 Хог хаягдлыг дуудлагаар буюу графикт хугацаанд гэрээний дагуу ачих үүрэг хүлээнэ.
- 2.6 Ажлын ачаалал, цаг үеийн нөхцөл байдлаас хамаарч графикт хугацаанд хогийг ачиж тээвэрлэж чадахгүй бол урьдчилан мэдэгдэнэ.

Зураг 2-23. Энгийн хог хаягдлын гэрээ

Үйлдвэрийн ажилчдад хог хаягдлын талаарх мэдлэгийг нэмэгдүүлэхийг зорьж хог хаягдлыг ангилан ялгах, бууруулах талаар сургалтыг зохион байгуулсан (Сургалтын материал мэдээллийг

удирдлага зохион байгуулалтын менежментийн хэсэгт дэлгэрэнгүй тусгав). Ажилчдад хог хаягдлыг ангилан ялгах дадал хэвшлийг бий болгохоор ахуйн болон хүнсний зориулалттай хуванцар савыг ялгах ажлыг эхлүүлээд байна. Үүний хүрээнд үйлдвэрт хуванцар савыг хаях боломжтой хогийн савуудыг байршуулан хогийг ангилан хаях боломжтой орчныг бүрдүүлэн зааварчилгаа өгч ажилласан. Ажилчид дахин боловсруулах боломжтой хуванцрыг бүрэн ангилж сурснаар цаашид бусад хог хаягдлыг ангилан хаях алхмуудыг нэмэгдүүлнэ.



Зураг 2-24. Хуванцар хаягдлыг хаях цэгт байршуулсан тэмдэглэгээнүүд


2023 онд үйлдвэрийн гадна талбай болон эргэн тойронд нийтийн цэвэрлэгээний ажлыг төлөвлөж 09-р сард ажилчдын хүрээнд хийж гүйцэтгэсэн. Мөн цэвэрлэгээний ажилчид тогтмол гадна талбайн цэвэрлэгээг хийсэн (Зураг 2-25).



Зураг 2-25. Гадна талбайн цэвэрлэгээний явц

3 Үйлдвэрийн хог хаягдал

Үйлдвэрийн хаягдал усыг “Цэвэр усаар хангах, бохир усыг татан зайлуулах, цэвэрлэх аж ахуй нэгжийн гэрээ”-г Дархан-Ус суваг ХК-тай байгуулж ажилладаг. Гэрээний 1.3 дагуу жил бүр тус гэрээг дүгнэж, тодотгол гэрээг байгуулдаг. Иймд 2023 онд мөн адил гэрээг тодотгож үйлдвэрийн хэрэглэсэн ус болон бохир нийлүүлсэн тооцоог сар бүр хийж төлбөрийг барагдуулсан.



Зураг 2-26. Дархан-Ус суваг ХК-ийн гэрээ, төлбөрийн баримт

Үйлдвэрийн түүхий эд материалыг зориулалтын талбайд буулгаж, бэлтгэж хадгалах цех рүү шилжүүлдэг. Мөн үйлдвэрийн зориулалтын бус талбайд буулгаж үл хог хаягдлыг цэвэрлэж ариутгалыг мал эмнэлгийн газраар хийлүүллээ.



Зураг 2-27. Түүхий эд материалын үлдэгдлийг цэвэрлэгээ

3 Аюултай хог хаягдал

Үйлдвэрийн технологит ашигласан химийн бодисын сав баглаа боодлын хаягдлыг Цэцүүх трейд ХХК- тай гэрээ байгуулж шилжүүлж ажиллаж байна. Үйлдвэрээс үүссэн нийт 5 төрлийн савлагааны хаягдлыг шилжүүлж устгуулсан.

СЭЗ-ийн сайд Үндэсний Статистикийн газрын
даргын 2017 оны 12 сарын 15-ны 347 тоот
тушаалын хавсралт

НЭХЭМЖЛЭХ №184

Байгууллагын нэр: Цэцүүх трейд ХХК Регистрийн дугаар: 2066521 Утас/факс: 70180632, 99057786 Банкны нэр: Голomt банк Дансны дугаар: 1715132986 /төг /	Төлөгч: Байгууллагын нэр: Нэхий таннери ХХК оп- 836 лх-593 Нэхэмжилсэн он: 2023.08.11 Барааны үнэ хүчинтэй байх хугацаа: 30хоног
--	--

№	Бараа материалын үнэ бүхий зүйлийн нэр	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Худалдах үнэ	
				Нэгж үнэ	Нийт үнэ
1	IBC	ш	3.00	26,000.00	78,000.00
2	200л торх	ш	5.00	7,900.00	39,500.00
3	120л торх	ш	30.00	4,800.00	144,000.00
4	Хуванцар канистр	кг	544.60	1,150.00	626,290.00
5	Төмөр жижиг сав	кг	19.00	900.00	17,100.00
6					-
				Дүн	904,890.00
				Нийт дүн	904,890.00

Нийт дүн: Есөн зуун дөрвөн мянга найман зуун ерэн төгрөг

ЦЭЦҮҮХ ТРЕЙД ХХК
ТӨМӨР ДУРГААЙН ХУВЬСГААРИЙН ХХК

ЭКО ҮЙЛДВЭР

САНХҮҮ

ТТМ1286 НЯГТНИН БОДЛОГЧ
УЛААНБААТАР ХОТ

Тамга

Зураг 2-28. Цэцүүх трейд ХХК-д шилжүүлсэн аюултай хог хаягдлын бүртгэл





Зураг 2-29. Цэцүүх трейд ХХК-д хог хаягдлыг шилжүүлэх явц

2.1.6 Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн биелэлт

Энэхүү Дархан арьс шир боловсруулах цогцолбор үйлдвэр төслийн орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн хэрэгжилтийг Дархан-Уул аймгийн Ус цаг уур, орчны шинжилгээний төвтэй хийсэн гэрээний дагуу 2 удаагийн шинжилгээг тус байгууллагын Байгаль орчны шинжилгээний лабораторитой хамтран гүйцэтгэсэн болно.

Хүснэгт 2-5 Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр

Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд	Байршил	Хугацаа ба давтамж
Агаарын чанар		
Агаар дахь органик биш нэгдэл - NO ₂ , SO ₂ - Нийт тоос	Салхины зонхилох чиглэл болон эх үүсвэрийн байршил дахь агаар бохирдуулагчийн тархалтыг гаргахад төлөөлөх чадвартай 1 цэгт	Жилд 2 удаа
Хөрсөн бүрхэвч		
Хөрсний ерөнхий хими Хүнд металлын үзүүлэлт	Төслийн талбай орчимд 2 цэгт	Жилд 2 удаа 2 цэгт
Усны чанар		
MNS 6561 : 2015 Ариутгах татуургын сүлжээнд нийлүүлэх хаягдал усны үзүүлэлтүүд	Цэвэрлэх байгууламжийн оролт, гаралтын ус	Жилд 2 удаа 2 цэгт

2.1.6.1 Үр дүн

2.1.6.1.1 Агаарын чанар

Байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу Дархан-Уул аймгийн Төв цэвэрлэх байгууламжийн эзэмшил талбай болон цэвэрлэх байгууламжийн гадна талбайгаас агаарын чанарын хяналт шинжилгээний 2 цэгийг сонгов.

Цэг сонгосон үндэслэл нь 1- р цэг буюу цэвэрлэх байгууламж доторх цэгийг барилгын ажил явагдаж байгаа талбайтай ойр замын хажууд сонгосон бол 2-р цэгийг цэвэрлэх байгууламжийн барилгын ажлын нөлөөлөлд өртөөгүй гадна талбайгаас сонгон авсан. Хоёр цэгт хийсэн хэмжилтийн утгыг хооронд болон холбогдох стандарттай нь харьцуулалт хийх зорилгын доор хийж гүйцэтгэлээ.

Судалгааны арга зүй

Үйлдвэрийн гадна талбайгаас агаарын хүхэрлэг хий (SO₂), азотын давхар исэл (NO₂), нийт тоосонцор (TSP) үзүүлэлтийг 4-р болон 11-р сар тус бүр 2 байршилд хэмжилт хийгдсэн.

Нийт тоосонцор: Төслийн талбай орчим дахь агаарт агуулагдах нийт тоосонцрын агууламжийг DustTrak зөөврийн багажийн тусламжтайгаар тодорхойлсон (Фото зураг 1).



Фото зураг 1. DustTrak загварын зөөврийн багаж

Dusttrack загварын багаж нь зайгаар ажилладаг лазер фотометр юм. Тус зөөврийн багаж нь 0.002-100 мг/м³ хүрээг хамран агууламжийг мг/м³ нэгжээр харуулдаг.

Хүхэрлэг хий болон Азотын давхар исэл. Хүхэрлэг хий болон азотын давхар ислийг тодорхойлохдоо химийн шинжилгээний аргачлалаар тодорхойлов.

Орчны агаар дахь хүхэрлэг хий, азотын давхар ислийн агууламжийг харгалзан MNS 17.2.5.11, MNS 17.2.5.12 аргачлалуудаар тодорхойлсон бөгөөд агаараас хийн сорьц авахад SIBATA Маркийн багаж ашигласан.



Зураг 2-30. Агаараас сорьц авсан багаж

Мониторингийн хэмжилт, дээжлэлтийн явцын зургийг Зураг 2-31-д харуулав.



Зураг 2-31. Мониторингийн хэмжилт, дээжлэлтийн явц

2.1.6.2 Хэмжилтийн үр дүн

Тухайн сорьц авах, хэмжилт хийх цаг хугацааны цаг агаарын нөхцөл:

- Агаарын чийгшил – 28%
- Агаарын температур – 14.1⁰C
- Салхи- 3 м/с /зүүн хойноос/

Тоосонцрын хэмжилт

Агаарын чанарын хяналтын 2 цэгт хийсэн нийт тоосонцрын хэмжээг “MNS 4585:2016 Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага” стандартын хүлцэх агууламжтай харьцуулахад стандартаас давсан үзүүлэлт илрээгүй хэвийн хэмжээнд байна. Нарийн болон том ширхэгт тоосонцрын хэмжилтийн утгыг Хүснэгт 2-6-т харуулав.

Хүснэгт 2-6. Тоосонцрын хэмжилтийн үр дүн

№	4-р сар		11-р сар	
	Хэмжилт	Нийт тоос, мкг/м ³	Хэмжилт	Нийт тоос, мкг/м ³
1	10401д	298	111016	43
2	10402д	324	111026	42
MNS4585:2016 зөвшөөрөгдөх дээд хэмжээ		500	MNS4585:2016 зөвшөөрөгдөх дээд хэмжээ	500

Агаар бохирдуулагч бодисын хэмжилт.

Агаарын чанарын хяналтын 2 цэгээс авсан хүхэрлэг хий болон азотын давхар ислийн хэмжээ “MNS 4585:2016 Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага” стандартын хүлцэх агууламжаас давсан үзүүлэлт илрээгүй хэвийн хэмжээнд байна.

Хүснэгт 2-7. Агаар бохирдуулагч бодисын хэмжилтүүд

№	4-р сар	NO ₂	SO ₂	11-р сар	NO ₂	SO ₂
		мкг/м ³			мкг/м ³	
1	10401д	8	28	111016	42	10
2	10402д	35	12	111026	36	9
MNS4585:2016 ЗДХ		200 мкг/м ³	450 мкг/м ³	MNS4585:2016 ЗДХ	200 мкг/м ³	450 мкг/м ³

2.1.6.2.1 Усны чанар

Энэхүү хэсгийг цэвэрлэх байгууламжид орж байгаа /20401г/ болон гаралтын уснаас /20402г/ дээжлэлт хийсэн шинжилгээний хариунд тулгуурлан боловсруулав.

Усны дээжийг авах: Дээж авахдаа он сар өдөр, төрөл, гадаад байдал, байршил координатыг тэмдэглэж авав. Усны дээжийг зориулалтын аргаар ариутгасан 1 литрийн багтаамжтай хуванцар саванд авсан. Усны дээжийн савыг нэрмэл усаар зайлж ариутгасан. Энэхүү хуванцар сав нь их концентрацитай бодис бүхий дээж хадгалаагүй худалдааны цэвэршүүлсэн цэвэр усны хуванцар сав юм. Усны дээж авахдаа савыг дүүргэн авч саванд агаар байх зайгүйгээр тагласан. Энэ нь тээвэрлэлтийн үед сэгсрэгдэх, хийнүүдийн хоорондох харилцан үйлчлэлийг хязгаарлах ач холбогдолтой.

Судалгааны үр дүн

Хүснэгт 2-8. Хаягдал бохир усны шинжилгээний хариу

№	Усны химийн шинжилгээний үзүүлэлт	Хэмжих нэгж	MNS6561:2015 ЗДХ	4-р сар		11-р сар	
				20401г	20402г	21101а	21102а
1	БХХ5	мг/л	400	1094.4	577.6	960.0	610.0
2	Жинлэгдэх бодис	мг/л	400	611.0	292.0	556	375.0
3	NH ₄	мгN/л	30		6.47		25.47
4	NO ₂	мгN/л			0.174		0.467
5	NO ₃	мгN/л			1.03	4.15	0.78
6	pH		6.0-9.0	8.43	6.91		3.72
7	Cr-VI	мг/л	0.050		0.025		0.014

8	Перманганатын исэлдэх чанар	мг/л		304	136.8	320	188
---	--------------------------------	------	--	-----	-------	-----	-----

2.1.6.2.2 Хөрсний чанар

Үйлдвэрийн талбайд нийт 2 байршилд диагнолийн аргыг ашиглан дээжлэлтийг хийсэн.

Судалгааны үр дүн

№	Үзүүлэлт	Хэмжих нэгж	MNS3297:2019 ЗДХ	4-р сар		11-р сар	
				30401г	30402г	31101а	31102а
1	Хөрсний ялзмаг	%		1.14	1.57	1.25	1.68
2	Нитрат, NO3	мг/кг	130	5.1	4.5	5.6	4.9
3	Сульфат, SO4	мг/кг	160	53.1	23.8	64.5	110.0
4	Аммони, NH4	мг/кг		18.1	22.2	20.5	22.0
5	pH			7.71	9.17	7.85	8.25
6	ЕС	μл/см		196.1	417.0	205.8	395.0

2.1.7 Удирдлага зохион байгуулалтын хүрээнд авч хэрэгжүүлэх арга хэмжээ

Төслийн явцад байгаль хамгаалах, сөрөг нөлөөллийг бууруулах, арилгахтай холбоотой арга хэмжээг тухай бүрд авч хэрэгжүүлэх шаардлагатай. Газрын чанарын улсын хянан баталгааг 5 жил тутамд хийлгэх шаардлагатай.

Хүснэгт 2-9 Удирдлага зохион байгуулалтын хүрээнд авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө

№	Хэрэгжүүлэх арга хэмжээ
1	Байгаль орчны удирдлага зохион байгуулалтын арга хэлбэрийг үйл ажиллагаандаа хэрэгжүүлэх чиглэлээр үүрэг хариуцлагын дотоод журам боловсруулж мөрдөх, байгаль орчны асуудал хариуцсан мэргэжилтэнтэй болох
2	Эх үүсвэрээс гарах хог хаягдлын кодчилсон жагсаалт, тэдгээрийн зэрэглэлийн дагуу хог хаягдлын төрөл, кодыг тогтоон ялгаж бүртгэл хөтлөх
3	Хог хаягдлыг ангилан ялгаж, гэрээт ААН (ачиж тээвэрлэх эрх бүхий байгууллагаар)-ээр төслийн талбайгаас тогтмол зөөвөрлүүлэх
4	Зориулалтын хог хаях цэгээс бусад газар хог хаягдал хаяхгүй байх, хог хаягдлыг ангилан ялгах арга хэмжээг хэвшүүлэх талаар ажилчдад заавар зөвлөгөө өгөх сургалт зохион байгуулах, самбар пайз байрлуулах
5	Байгаль орчныг хамгаалах, үйл ажиллагааны осол, гал түймэр, гэнэтийн ослоос урьдчилан сэргийлэх, осол гарсан тохиолдолд шуурхай хэрэгжүүлэх арга хэмжээг зохион байгуулах
6	Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 2-р бүлгийн 101 дүгээр зүйлийн 1-д заасны дагуу байгаль орчны аудитыг эрх бүхий мэргэжлийн байгууллагаар хийлгэж, холбогдох дүгнэлт, зөвлөмж гаргуулан
7	Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлж, орчны хяналт шинжилгээг хийх. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийг холбогдох байгууллагаар дүгнүүлэх
8	Төслийн талбайд хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, техник ашиглалтын талаарх мэдээлэл бүхий самбарыг байршуулах, мэдээллийг цаг тухай бүрд нь шинэчилж байх
9	Эзэмшлийн талбайд газрын төлөв байдлын чанарын улсын хянан баталгааг эрх бүхий байгууллагаар хийлгэх
10	Тэрбум мод хөтөлбөрийн хүрээнд орон нутагтай хамтран ажиллаж, орон нутгаас санал болгосон талбайд мод тарих, дэмжлэг үзүүлэх

11	Үйлдвэрийн барилга байгууламжийн дэд бүтцийн /Дулаан, уур, цэвэр, бохир ус, цахилгаан/ холбогдох гэрээг холбогдох байгууллагуудтай сунгах, төлбөрийг тогтмол төлөх
----	--

Удирдлага зохион байгуулалтын хүрээнд авч хэрэгжүүлэх арга хэмжээний хүрээнд нийт 11 ажлыг хийж гүйцэтгэхээр төлөвлөсөн үүний хүрээнд гүйцэтгэлийг дараах байдлаар хангууллаа.

1. Байгаль орчны удирдлага зохион байгуулалтын арга хэлбэрийг үйл ажиллагаандаа хэрэгжүүлэх чиглэлээр үүрэг хариуцлагын дотоод журам боловсруулж мөрдөх, байгаль орчны асуудал хариуцсан мэргэжилтэнтэй болох

Дархан арьс шир боловсруулах цогцолбор үйлдвэр Монгол улсын хуулийн хүрээнд байгаль орчинд ээлтэй үйл ажиллагаа явуулахын хүрээнд дотооддоо байгаль орчны дотоод, бодлого журмын боловсруулан батлан хэрэгжүүлж ажиллаж байна. Дотоод журмыг 2023 оны 05-р сарын 01-ны өдөр Нэхий таннери ХХК-ийн захирал баталж хэрэгжилтийг хангахыг байгаль орчны мэргэжилтэнд үүрэг болгосон.

Дархан арьс шир боловсруулах цогцолбор үйлдвэрийн үйл ажиллагааг Монгол улсын хуулийн хүрээнд байгаль орчныг хамгаалах, үйл ажиллагааг эрхлэхийг хариуцан ажиллуулахаар Байгаль орчны мэргэжилтэнтэй 2023 оны 03-р сарын 22-ны өдөр А. Ану-Үжин гэрээ байгуулж ажиллаж байна. Байгаль орчны мэргэжилтний гэрээг хавсралтаар орууллаа.

2. Эх үүсвэрээс гарах хог хаягдлын кодчилсон жагсаалт, тэдгээрийн зэрэглэлийн дагуу хог хаягдлын төрөл, кодыг тогтоон ялгаж бүртгэл хөтлөх Үйлдвэрийн үйл ажиллагаанаас үүсэх хог хаягдлыг Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2017 оны 12-р сарын 12-ны өдрийн А/349 тушаалын дагуу эх үүсвэрээс гарах хог хаягдлын кодчилсон бүртгэл үүсгэсэн. Нэхий таннери ХХК-иас үүсэх хог хаягдлын кодчилсон бүртгэлийг доорх хүснэгтэд харуулав.

Хүснэгт 2-10. Нэхий таннери ХХК-ийн үйлдвэрийн хог хаягдлын кодчилсон хүснэгт


Хог хаягдлын нэр	Хог хаягдлын бүлэг	Хог хаягдлын дэд бүлгийг	Дэд бүлгээс үүсэх хог хаягдлын төрлийг	Тэмдэглэгээ
Үйлдвэрлэлийн хог хаягдал	04- Арьс шир, үслэг эдлэл, ноос, ноолуурын үйлдвэрлэлийн хаягдал	01-Арьс шир, үслэг эдлэлийн үйлдвэрлэлийн хаягдал	Хром агуулсан хаягдал усны анхан шатны цэвэрлэгээнээс үүсэх лаг	04 01 06*- Хортой “Х”
			Идээлсэн арьсны хром агуулсан хаягдал (хөх арьс, зоргодос, тайрдас, хуулга)	04 01 08
			Тусгайлан заагдаагүй бусад хог хаягдал	04 01 99
Химийн бодисын сав баглаа боодол	08- Гадаргуу бүрэгч материал (будаж, лак, паалан), цавуу, чигжээс, хэвлэлийн будаг үйлдвэрлэх, бэлтгэх, тээвэрлэх, хэрэглэх үед үүсэх хаягдал	01- Будаг, лак үйлдвэрлэх, бэлтгэх, тээвэрлэх, хэрэглэх, арилгах үед үүсэх хаягдал	08 01 05-д зааснаас бусад будаг, лакны усархаг шингэн лаг	08 01 06
	15-Сав баглаа боодлын хаягдал: Шингээгч, бохир алчуур материал, фильтрйн материал, тусгайлан заагдаагүй хамгаалалтын хувцас	01 - Сав баглаа боодол (ангилян ялгасан ахуйн сав баглаа боодлын хаягдал орно)	02- Хуванцар сав баглаа боодол	15 01 02
Ахуйн үйл ажиллагаанаас	16- Бусад хог хаягдал	06- Батерей, аккумулятор	04- Шүлтийн батерей (16 06 03-аас бусад)	16 06 04 -
			09-Хортой бодисын үлдэгдэл агуулсан эсвэл бохирдсон сав баглаа боодол	15 01 09 – “Аюултай” А
Үйлдвэрийн үйл ажиллагаанаас гарах	16- Бусад хог хаягдал	02- Цахилгаан болон цахим тоног төхөөрөмжийн хаягдал	06- 16 02 01 - 16 02 05 -д зааснаас бусад хаягдал тоног төхөөрөмж	16 02 06 -
Цаас	20 - Ахуйн хог хаягдал (түүнтэй найрлага, бүтцийн хувьд ижил үйлдвэр, үйлчилгээ, албан байгууллагын хог хаягдал)	01 - Ангилж цуглуулсан хог хаягдал (15 01 -ээс бусад)	01 - Цаас, картон	20 01 01- Энгийн
Мод			26- 20 01 25-д зааснаас бусад төрлийн мод, модон эдлэл	20 01 26 - Энгийн
Гялгар уут			99 - Тусгайлан заагдаагүй бусад хог хаягдал	20 03 99 - Энгийн
Бусад ахуйг хог хаягдал			03- Бусад ахуйн хог хаягдал	01 - Холимог ахуйн хог хаягдал

3. Хог хаягдлыг ангилан ялгаж, гэрээт ААН (ачиж тээвэрлэх эрх бүхий байгууллагаар)-ээр төслийн талбайгаас тогтмол зөөвөрлүүлэх


Хог хаягдлын тухай хуулийн шинэчилсэн найруулга /2017/ болон Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2018 оны А/443 дугаар тушаалаар батлагдсан “Энгийн хог хаягдлыг ангилах, цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, сэргээн ашиглах, устгах, булшлах үйл ажиллагаанд тавигдах ерөнхий шаардлага”-д тус тус зааснаар төсөл хэрэгжүүлэгч Нэхий таннери ХХК нь үүссэн хог хаягдлыг 1. Дахин боловсруулах боломжтой 2. Дахин боловсруулах боломжгүй 3. Хүнсний органик хог хаягдал гэж төрөлжүүлэн эх үүсвэр дээр ангилан зохих аж ахуй нэгжид хүлээлгэн өгч тээвэрлүүлж байна.

Дээрх ангиллаас гадна үүссэн хог хаягдлыг кодчиллын дагуу энгийн болон аюултай хог хаягдлыг тусгай эрх бүхий байгууллагад шилжүүлж зохих устгалыг хийлгүүлж ажилласан.

Компанийн хувьд энгийн хог хаягдлыг Дархан хотын тохижилт үйлчилгээний газартай, аюултай хог хаягдлыг Цэцүүх трейд ХХК-тай гэрээ байгуулан хамтран ажиллаж байна. Гэрээний загварыг доорх зурагт харууллаа.



Дархан хотын тохижилт үйлчилгээний газар



Цэцүүх трейд ХХК

Зураг 2-32. Хог хаягдлыг гэрээнүүд

Хүснэгт 2-11.

	Ангилал	Үүсэх хог хаягдал	Шилжүүлэх байгууллага
1	Дахин боловсруулах боломжтой	-Хуванцар /ажилчид болон хоолны газраас үүсэх ундаа, усны хуванцар сав/	Энгийн хог хаягдал – Дархан хотын тохижилт үйлчилгээний газар

2	Дахин боловсруулах боломжгүй	-Үйлдвэрийн хог хаягдал /аюултай болон энгийн / -Ажилчдын хог хаягдал -Оффис	Энгийн хог хаягдал – Дархан хотын тохижилт үйлчилгээний газар Аюултай хог хаягдал- Цэцүүх трейд ХХК
3	Хүнсний органик хог хаягдал	-Хоолны газар	Энгийн хог хаягдал – Дархан хотын тохижилт үйлчилгээний газар

2023 оны 1-р сараас 10-р сарын хугацаанд үүссэн энгийн хог хаягдлыг тээвэрлүүлж, Дархан хотын тохижилт үйлчилгээний газарт, аюултай хог хаягдлыг Цэцүүх трейд ХХК-д шилжүүлсэн бүртгэсэн.


СЭЗ-ийн сайд Үндэсний Статистикийн газрын
даргын 2017 оны 12 сарын 15-ны 347 тоот
тушаалын хавсралт

НЭХЭМЖЛЭХ №184

Байгууллагын нэр:	Төлөгч:
Цэцүүх трейд ХХК	Байгууллагын нэр:
Регистрийн дугаар: 2066521	Нэхий таннери ХХК
Утас/факс: 70180632, 99057786	өп- 836 дх-593
Банкны нэр: Голomt банк	Нэхэмжилсэн өн: 2023.08.11
Дансны дугаар: 1715132986 /төг /	Барааны үнэ хүчинтэй байх хугацаа: 30хоног

№	Бараа материалын үнэ бүхий зүйлийн нэр	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Худалдах үнэ	
				Нэгж үнэ	Нийт үнэ
1	IBC	ш	3.00	26,000.00	78,000.00
2	200л төрх	ш	5.00	7,900.00	39,500.00
3	120л төрх	ш	30.00	4,800.00	144,000.00
4	Хуванцар канистр	кг	544.60	1,150.00	626,290.00
5	Төмөр жижиг сав	кг	19.00	900.00	17,100.00
6					-
				Дүн	904,890.00
				Нийт дүн	904,890.00

Нийт дүн: Есөн зуун дөрвөн мянга найман зуун ерэн төгрөг

Тамга  *Дунца*

Нягтлан бодогч
УЛААНБААТАР ХОТ

Зураг 2-33. Аюултай хог хаягдал нийлүүлсэн бүртгэл

- Зориулалтын хог хаях цэгээс бусад газар хог хаягдал хаяхгүй байх, хог хаягдлыг ангилан ялгах арга хэмжээг хэвшүүлэх талаар ажилчдад заавар зөвлөгөө өгөх сургалт зохион байгуулах, самбар пайз байрлуулах

Үйлдвэрийн ажилчдыг хог хаягдлыг талаар, мөрдөж буй хууль эрх зүй, ангилан ялгах арга хэмжээг хэвшүүлэх талаарх сургалтыг 2023 оны 5-р сард хэсэгчилсэн байдлаар явуулсан. Сургалтын явц болон агуулгын талаарх зургийг доор харууллаа.

Байгаль орчны багц хуулиуд тэдгээрт нийцүүлэн гаргасан журам, тогтоол, байгаль орчны стандартуудын заалтууд болон байгууллагын 2021 онд хийгдсэн БОННҮ-ний тайлангийн нийцлийн аудитыг Энвайроментал комплайнц ХХК-ийн ахлах аудитор Б.Энхбаяр, аудитор Б.Номин-эрдэнэ, туслах аудитор: П.Галмандах нарын баг бүрэлдэхүүнтэй хийж гүйцэтгэсэн.

Байгаль орчны хууль тогтоомжийн нийцлийн хөндлөнгийн аудит ажлын хүрээнд № EAR2023/26 дугаартай аудитын тайлан, дүгнэлт, зөвлөмж гарсан болно.

БАЙГАЛЬ ОРЧНЫ ХУУЛЬ ТОГТООМЖИЙН
НИЙЦЛИЙН ХӨНДЛӨНГИЙН АУДИТ
Аудитын тайлан № E.AR2023/26

4 Байгаль орчны аудитын зөвлөмж

Дархан-уул аймгийн Дархан сумын нутагт орших Нэхий таннери ХХК-ийн “Арьс шир боловсруулах үйлдвэрийн цогцолбор” төслийн үйл ажиллагаанд байгаль орчны аудит хийх явцад илэрсэн үл тохирол ба эдгээр үл тохирлыг хэрхэн засах, аудитын явцад хийж гүйцээгүй болон хийгдэж байгаа арга хэмжээнүүдэд дараах зөвлөмжүүдийг өглөө. Энэхүү зөвлөмжид зарим авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээнүүд багтсан болно. Үүнд:

1. Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 31.6-д заасны дагуу Экологийн паспорт хөтлөх. MNS.4219:1994 Байгаль орчны хамгаалал. Аж ахуйн нэгжийн экологийн паспорт. Үндсэн дүрэм стандартыг худалдан авч, стандартын дагуу Экологийн паспорт хөтлөх.
2. Химийн хортой болон аюултай бодисын тухай хуулийн 13.3-т заасны дагуу өөрийн аюулгүй ажиллагааны журмыг боловсруулан орон нутгийн эрүүл ахуйн болон байгаль орчны хяналтын байцаагчаар хянуулан үйл ажиллагаандаа ашиглах
3. Хог хаягдлын тухай хуульд заасны дагуу аюултай болон энгийн хог хаягдалтай холбоотой аливаа асуудлыг зохицуулах үүрэг бүхий нэгж эсвэл ажилтан томилогдоогүй байгаа тул өөрийн үйл ажиллагааны цар хүрээнд тохирох нэгж эсвэл ажилтан томилох

Энэхүү зөвлөмжийг хэрэгжүүлээд хэрхэн хэрэгжүүлсэн тайлангаа дараагийн төлөвлөгөөт аудитаас өмнө аймгийн БОАЖГ-т хүргүүлэх.

Б.Энхбаяр

Ахлах аудитор,

Энвайроментал комплайнц ХХК-ийн

Захирал



Environmental
Compliance

Хаяг: Далай тээр 303 тоот, Сүхбаатар
дүүрэг, 1-р хороо, ЮНЕСКО-ий гудамж
31 Улаанбаатар 14230, Монгол улс
Утас: +976 70000802
Гар утас: 99083500
Имэйл: enheecz@gmail.com

БАЙГАЛЬ ОРЧНЫ ХУУЛЬ ТОГТООМЖИЙН
НИЙЦЛИЙН ХӨНДЛӨНГИЙН АУДИТ
Аудитын тайлан № EA2023/26

АУДИТЫН ДҮГНЭЛТ

Нэхий таннери ХХК-ийн "Арьс шир боловсруулах үйлдвэрийн цогцолбор" төслийн үйл ажиллагаанд "Байгаль орчныг хамгаалах тухай хууль" –ийн 10¹ дугаар зүйлд заасны дагуу Байгаль орчны багц хуулиуд тэдгээрт нийцүүлэн гаргасан журам, тогтоол, байгаль орчны стандартуудын заалтууд болон үйлчлүүлэгч байгууллагын 2021 онд хийгдсэн БОННУ-ний тайлангийн нийцлийн аудитыг 2023 оны 11-р сарын 03-10-ны өдрүүдийн хооронд хийж гүйцэтгэв.

Тус байгаль орчны аудитыг төслийн БОННУ болон бусад БО-ны баримт бичгүүдийн хяналт, төслийн талбай дээрх шалгалт, холбогдох ажилтнуудтай хийсэн ярилцлага болон цуглуулсан баримт нотолгоо дээр үндэслэн аудитын дүгнэлт, зөвлөмж боловсруулах зэрэг үндсэн үйл ажиллагааны дагуу хийв.

Нэхий таннери ХХК-ийн "Арьс шир боловсруулах үйлдвэрийн цогцолбор" төсөл 1974 оноос эхлэн үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд Байгаль орчны хууль тогтоомжийг хэрэгжүүлэх ажилд хэрхэн анхаарал хандуулж ажилладаг болохоо шалгуулахаар байгаль орчны төлөвлөгөөт аудит хийлгэж байгаа нь байгаль орчны асуудалд ач холбогдол өгч байгааг илэрхийлэх сайшаалтай явдал юм.

Төслийн үйл ажиллагаанууд нь хууль эрх зүйн хувьд нийт 18 хуулийн 196 зүйл заалтаас төслийн үйл ажиллагаатай хамаарал бүхий 99 зүйл заалтаас нийцлийн 83 заалт буюу 83.8%, үл нийцэл 3 заалт буюу 3%, тодорхойгүй 13 заалт буюу 13.1% байлаа.

Үл тохиролд орсон заалт нь хэрэгжүүлэх зайлшгүй шаардлагатай бөгөөд Экологийн паспорт хөтлөх, химийн бодистой ажиллах өөрийн аюулгүй ажиллагааны журам боловсруулаагүй, энгийн болон аюултай хог хаягдалтай хамааралтай асуудлыг зохицуулах үүрэг бүхий ажилтан томилоогүй зэрэг зүйлс байгааг анхаарч ажиллахыг зөвлөө.

Аудитын хугацаанд үйлчлүүлэгч байгууллагын холбогдох ажилтнууд дэмжин хамтран ажилласан бөгөөд ямар нэгэн саад тотгор, хөндлөнгөөс нөлөөлөх байдал гараагүй болно.

Гарын үсэг:

Огноо: 2023.11.20



Б. Энхбаяр, Ахлах аудитор



Хаяг: Далай тауэр 303 тоот, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, ЮНЕСКО-гийн гудамж 31 Улаанбаатар 14230, Монгол улс
Утас: +976 70000802
Гар утас: 99083500
Имэйл: enheecz@gmail.com

7. Төслийн талбайд хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, техник ашиглалтын талаарх мэдээлэл бүхий самбарыг байршуулах, мэдээллийг цаг тухай бүрд нь шинэчилж байх
Үйлдвэрийн байгууламж доор нийт 2 байршилд хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, техник ашиглалтын талаарх мэдээлэл бүхий самбар байршдаг бөгөөд 09 сард самбаруудын мэдээллийг дахин шинэчилсэн.

8. Эзэмшлийн талбайд газрын төлөв байдлын чанарын улсын хянан баталгааг эрх бүхий байгууллагаар хийлгэх
“Газрын тухай хууль” -ийн 35.3.4-т заасны дагуу газрын төлөв байдал, чанарын улсын хянан баталгааг Анализ мэт про ХХК-тай гэрээ байгуулж хийж гүйцэтгүүлээ.

ГАЗРЫН ТӨЛӨВ БАЙДАЛ, ЧАНАРЫН ХЯНАН БАТАЛГААНЫ ДҮГНЭЛТ

1

ГАЗРЫН ТӨЛӨВ БАЙДАЛ, ЧАНАРЫН ХЯНАН БАТАЛГААНЫ ДҮГНЭЛТ

Хянан баталгааны төрөл: Захиалгат хянан баталгаа **Огноо:** 2023-06-08

1. Газар ашиглагч: Нэхий таннери ХХК
2. Аймаг (нийслэл): Дархан-Уул Сум (дүүрэг): Дархан
3. Байршил, хаяг: 13-р баг, Үйлдвэрчин-5, 502
4. Нэгж талбарын дугаар: 4505100271
5. Хөрсний нэр:
6. Ургамалжилт:
7. Нийт талбайн хэмжээ: 89077 м²
8. Газар эзэмших зориулалт: Үйлдвэрлэлийн барилга, байгууламж, бусад газар
9. Одоогийн газар ашиглалтын хэлбэр: Үйлдвэрлэлийн барилга, байгууламж, бусад газар
10. Газар ашиглах, эзэмших шийдвэр: Дархан-Уул аймаг /нийслэл/-ийн Дархан сум/дүүргийн Засаг даргын 2020 оны 03 дугаар сарын 13-ний өдрийн 04501-01-А/98/2020 тоот захирамж
11. Газар эзэмших эрхийн гэрчилгээний дугаар: 000013634
12. Эзэмшил газрын төлөв байдал, чанарын тодорхойлолт
Газрын кадастрын солбицолоор талбайн хэмжээг тооцоход 89109 м² талбай байна. Энэ нь системд алдаатайгаар 89077 м² болж тооцогдож байна.

Газрын төлөв байдал, чанарын тодорхойлолт

Газар ашиглалтын байдал	Талбай	Эвдэрч бохирдсон талбай		
		Физикийн	Химийн	Биологийн
Нийт эзэмшил газар	89109	-	-	-
Нэгж талбарын талбай	89109	-	-	-
Газар дээрээ ашиглаж байгаа талбай	89109	-	-	-
Дутуу ашиглаж байгаа газар	-	-	-	-
Илүү ашиглаж байгаа газар	-	-	-	-
А.Зөвшөөрөлтэй ашиглаж байгаа талбай				
1.Үйл ажиллагаанд өртөөгүй талбай				
Сул чөлөөтэй талбай	50294	-	-	-
2.Үйл ажиллагаанд өртсөн талбай				
Барилга	24640	+	-	-
Бетон талбай	3766	+	-	-
Зоорь	66	+	-	-
Төмөр зам	424	+	-	-
Лагийн талбай	9791	+	-	-
Явган зам	128	+	-	-

13. Газар ашиглалтын онцлог, гадаргын төлөв байдал

Уг нэгж талбар нь Дархан-Уул аймгийн Дархан суманд Дархан дулааны цахилгаан станцын урд байрлана. Нийт 89109 м² талбай эзэмшдэг бөгөөд үүний 38815 м² талбай буюу 43.55 % нь физик эвдрэлд орсон байна. Үүнээс 24640 м² нь барилга, 3766 м² нь бетон талбай, 66 м² нь зоорь, 424 м² нь төмөр зам, 9791 м² лагийн талбай, 128 м² нь явган зам байна. Автомашин зорчих хэсэг, явган хүний зам талбай бетон хучилттай. Элдэв химийн болон ахуйн бохирдолт байхгүй.

14. Хөрсний доройтол, бохирдолт, түүний төрөл, зэрэглэл

Хөрсний нэр: Хар хүрэн хөрс /2202/

Хөрсний механик бүрэлдэхүүн

Цэгийн дугаар	Давхарга	Жижиг хэсгийн эзлэх хэмжээ мм, хувиар
---------------	----------	---------------------------------------

ГАЗРЫН ТӨЛӨВ БАЙДАЛ, ЧАНАРЫН ХЯНАН БАТАЛГААНЫ ДҮГНЭЛТ

2

		Гүн см	1-0.25	0.25-0.05	0.05-0.01	0.01-0.005	0.005-0.001	0.001-с бага	0.01-с бага
4505100271001001	A	0-20	4.1	69.4	16	2	6.4	2.1	10.5

Хөрсний механик бүрэлдэхүүний хувьд элсэнцэр, 0.01мм-ээс бага диаметртэй физик шаврын хэмжээ 10.5 % байна.

Хөрсний агрохимийн шинж чанар

Цэгийн дугаар	Давхарга	Гүн см	Ялзмаг, %	pH	ЦДЧ, dsm	Давс, %	CaCo3, %	Солилцох суурь, мг-экв/100гр		Шим тэжээлийн элементүүд мг/100гр	
								Ca	Mg	K2O	p2o5
4505100271001001	A	0-20	1.38	8.9	0.054	0.03	0.66	12.6	1.6	37	2.9

Уг хөрсний агрохимийн шинж чанарыг үзвэл урвалын орчин хүчтэй шүлтлэг, ялзмаг агууламж өнгөн үе давхаргадаа 1.38 % буюу бага, бага зэрэг карбонаттай буюу давсжилт бага, шингээх багтаамж дунд, үржил шимийн хувьд 100 г хөрсөнд хөдөлгөөнт фосфор 2.9 мг буюу дунд, хөдөлгөөнт кали 37 мг буюу хангалттай хэмжээгээр хангагдсан байна.

Хөрсний эрүүл ахуйн шинжилгээ

Цэгийн дугаар	Давхарга	Нянгийн тоо	Гэдэсний савханцарын таньц	Перфингенсийн таньц
4505100271001001	A	7.0*10	0.1	0.1
4505100271001003	A	3.0*10	1	0.1

Дээж-1 /Зоорь орчим/ хөрсний эрүүл ахуйн шинжилгээ хийлгэхэд хөрсөн дах нянгийн тоо 7.0*10 буюу цэвэр, анаэробын таньц 0.1 буюу цэвэр, гэдэсний савханцарын хэмжээ 0.1 буюу бага зэргийн бохирдолтой байна. Дээж-2 /лагийн талбай ойролцоо/ хөрсний эрүүл ахуйн шинжилгээ хийлгэхэд хөрсөн дах нянгийн тоо 3.0*10 буюу цэвэр, анаэробын таньц 0.1 буюу цэвэр, гэдэсний савханцарын хэмжээ 1.0 буюу цэвэр байна.

Хөрсөн дэх зарим хүнд металлын агууламж /үндсэн/

Цэгийн дугаар	Давхарга	Хүнд металлын агууламж, мг/кг					
		Pb /Хар тугалга/	Cd /Кадми/	Zn /Цайр/	Cu /Зэс/	Ni /Никель/	Cr /Хром/
4505100271001002	A	25.1		82.8	14.8	27.9	49.1
4505100271001003	A	24.7		84.5	24.9	18.4	48.6
4505100271001004	A	29.3		88.1	22	16.1	38.7

Үйлдвэрийн талбайн гадна, лагийн талбайн ойролцоо, хаягдал ихтэй талбай зэрэг хөрсний бохирдол бий болох магадлал өндөр байршилаас 3 дээж авч шинжлүүлэхэд кадми илрээгүй, цайр, хром, хар тугалга, зэс, никель гэх мэт хүнд металлын агууламж MNS 5850:2019 стандарт хэмжээнээс бага гарсан учир хөрс бохирдолгүй байна.

15. Ургамлын нөмрөгийн төрх байдал, доройтолын зэрэглэл

Ургамалжилт: Жижиг дэгнүүл-үетэн/ X-II-2-26/

Ургамлан нөмрөгийн төлөв байдал

Цэгийн дугаар	Үзүүлэлт							
	Ургамлын бүрхэц % /1 м2/	Ургамлын бүрхэц % /100 м2 талбайд/	Зүйлийн бүрэлдэхүүн тоо /1 м2 талбайд/	Зүйлийн бүрэлдэхүүн тоо /100 м2 талбайд/	Талхлагдлын заагуур ургамлын бүрхэц, %	Халцай газрын хэмжээ, %	Хад, Чулууны хэмжээ, %	1 га-н Ургац /ц/га

450510027100 1005	40	40	6	8	30	3	
----------------------	----	----	---	---	----	---	--

Энд 35-40 %-ийн ерөнхий бүрхэцтэй их талхлагдсан жижиг дэгнүүлт-үетэн бүлгэмдэл ноёлж байсан ба 1 м2 талбайд 5-6 зүйл, 10 м2 талбайд 7-8 зүйл ургамал тааралдана. Ургамлын зүйлийн бүрэлдэхүүнд шарилж 15-20 %-ийн бүрхэцтэй ноёлж бага бүрхэцтэйгээр үетэн, алаг өвс оролцон ургана.

16. Усны чанар, төлөв байдал

17. Газар ашиглалтын зөрчил, аюулгүй байдал:

Өндөр хүчдэл, гуу жалга, үерийн ам, гал зэрэг газар ашиглалтын аюулгүй байдал ноцтой зөрчигдөөгүй. Ахуйн болон химийн бохирдол илрээгүй

18. Газар ашиглалтын талаар цаашид авах арга хэмжээ, зөвлөмж

Хог хаягдлын зохистой менежментийг хэрэгжүүлэх, хогийг ангилан ялгаж, зориулалтын хогийн саванд цуглуулан тээвэрлэгч компанид хүлээлгэн өгч баримтжуулах.,

Үйлдвэрлэлийн гаралтай хог хаягдлыг ил задгай хаяхгүй байх, түүхий эдийг буулгах зам талбайг засаж янзалж хадгалах.,

Газрын тухай хуулийн 50.1.1 заасны дагуу “Хөрсийг элэгдэх эвдрэх, хуурайших, намагжих, давсжих, бохирдох, хордохоос сэргийлэх арга хэмжээг өөрийн зардлаар хариуцан гүйцэтгэдэг байх. Үүний тулд барилга байгууламж барих үед эвдэрсэн хөрсийг нөхөн сэргээж, ургамалжуулах.,

Бетон хучилттай талбайн бүрэн бүтэн байдалд анхаарал тавьж эвдэрсэн тохиолдолд хурдан шуурхай засаж байх.,

5 жил тутам газрын төлөв байдал, чанарын хянан баталгаа хийлгэж өмнө өмнөх онуудтай харьцуулан дүгнэлт гаргуулах.,

Хөрсөн дэх хүнд металлын агууламж нэмэгдэж, буурч байгаа эсэхэд хяналт тавьж стандарт хэмжээнээс хэтэрсэн тохиолдолд бууруулах арга хэмжээг авч хэрэгжүүлэх.,

Дүгнэлт гаргасан:
Газрын мэргэжлийн байгууллага
“АНАЛИЗ МЭП ПРО”ХХК




БАТАЛГААЖСАН.



ГАЗАР ЗОХИОН БАЙГУУЛАЛТ, ГЕОДЕЗИ,
ЗУРАГ ЗҮЙН ГАЗАР /Суурь судалгаа, мониторингийн
асуудал хариуцсан мэргэжилтэн/

“Нэхий таннери” ХХК-ийн хэрэгжүүлж буй “Дархан арьс шир боловсруулах цогцолбор үйлдвэр” төслийн 2023 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайлан



9. Тэрбум мод хөтөлбөрийн хүрээнд орон нутагтай хамтран ажиллаж, орон нутгаас санал болгосон талбайд мод тарих, дэмжлэг үзүүлэх

Нэхий таннери ХХК нь 2023 оны хүрээнд Монгол улсын тэрбум мод хөтөлбөрийн хүрээнд 20 мод тарихаар төлөвлөсөн бөгөөд 2023 оны 10-р сарын 18 өдөр Дархан-Уул аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газарт мод тарих байршлыг тогтоолгох албан бичиг хүргүүлсэн. Үүний хүрээнд Өгөөж ирээдүй ХХК-иас 20 ширхэг Агч модыг худалдан авч “Дархан хотын соёл амралтын хүрээлэн”-д 2023 оны 10-р сарын 27 өдөр тарьж хүлээлгэн өглөө.




Зураг 2-37. Мод тарих явц /2023.10.30/

10. Үйлдвэрийн барилга байгууламжийн дэд бүтцийн /Дулаан, уур, цэвэр, бохир ус, цахилгаан/ холбогдох гэрээг холбогдох байгууллагуудтай сунгах, төлбөрийг тогтмол төлөх Нэхий таннери ХХК-ийн үйлдвэрийн байгууламжийн дулаан, уур, цэвэр, бохир ус, цахилгаан хамгамжийг дараах байгууллагуудтай гэрээтэй ажилладаг болно.

			Гэрээ сунгасан хугацаа
1	Дулаан эрчим хүч	Дархан дулааны сүлжээ ТӨХК	
2	Цахилгаан эрчим хүч	Дархан сэлэнгэ цахилгаан түгээх сүлжээ ХК	2023 оны 12-р сарын 31
3	Цэвэр усаар хангах, бохир усыг татан зайлуулах, цэвэрлэх	Дархан ус суваг ХК	2024 оны 10-р сарын 01

Дулаан эрчим хүчээр хангах гэрээ нь 2022 оны 10-р сарын 05 өдрөөс 2023 оны 10-р сарын 01-ийг хүртэл хийгдсэн бөгөөд гэрээний нөхцөл шаардлагын дагуу 2024 оны гэрээ дахин хийж сунгуулсан.

Цахилгаан эрчим хүчээр хангах гэрээний хугацаа 2023 оны 12-р сарын 31-р дуусгавар болох тул 2024 онд сунгалт хийгдэхээр байна.



Зураг 2-38. Цахилгаан эрчим хүчээр хангах гэрээ

Цэвэр усаар хангах, бохир усыг татан зайлуулах, цэвэрлэх Дархан-Ус суваг ХК-тай байгуулсан гэрээ 2023 онд дахин байгуулж 2024 оны 10-р сарын 01-ны өдөр хүртэл хүчинтэй.

ДАРХАН-УС СУВАГ ХК

Хэрэглэгчид үсэнд төлбөр тавих хугацаа: сар Улирал

Гэрээний төрөл: Тур Байнгын

Гэрээ өөрчлөх болсон шалтгаан:

Хэрэглэгчийг төлөөлж гарын үсэг:

Хангалчийн итгэмжлэгдсэн төлөөлөгч
Албан тушаал: Хяналтын инженер
Овог нэр: А. Нямсүх
Гарын үсэг: А. Нямсүх

2024 оны 10 сарын 10 өдөр

Төлбөр тооцох тариф

№	Яндангийн голч /мм/	Усны хурд м3/сек	Зардлын м3/сар	Суурь хураамж /төг/
1	15	1.5	911	
2	20	1.5	1218	
3	25	1.5	1903	
4	32	1.5	3112	
5	40	1.5	4872	
6	50	1.5	7612	
7	80	1.5	19487	69880
8	100	1.5	30449	
9	25	1.5	42576	
10	150	1.5	68510	
11	200	1.5	121795	
12	250	1.5	190306	
13	300	1.5	274039	

6

Батлав:

Батлав: "Дархан-Ус суваг" хк-ний
Захирагч: Г.Ордаабаат

Цэвэр, бохир усны 2024 оны 10 тоот гэрээний
Жилийн хэрэгцээний тооцоо

нэр төрөл	1-р улирал			2-р улирал			3-р улирал			4-р улирал			Жилийн дүн
Хүйтэн ус/м³	2700	2700	2700	2700	2700	2700	2700	2700	2700	2700	2700	2700	30600
Халуун ус/м³													
Бохир ус /м³	3000	3000	3000	3000	3000	3000	3000	3000	3000	3000	3000	3000	42000

Тодотгол: Чингисдорж Ламсүх Дархан нхкх тус тус харилцан тохирч хийв.

Хэрэглэгчийг төлөөлж: А. Нямсүх ажилтай
Овогтой: А. Нямсүх
Гарын үсэг: А. Нямсүх

Хангалчийг төлөөлж: Г.Ордаабаат ажилтай
Овогтой: Г.Ордаабаат
Гарын үсэг: Г.Ордаабаат

Энэхүү гэрээ нь 2024 оны 10 сарын 10 өдөр хүртэл хүчинтэй

ДАРХАН-УС СУВАГ ХК

Зураг 2-39. Цэвэр усаар хангах, бохир усыг татан зайлуулах, цэвэрлэх гэрээ

Нэхий таннери ХХК-ийн үйл ажиллагаанд ашигласан дулаан, цахилгаан, цэвэр, бохир ус нийлүүлсэний төлбөрийг гэрээнд заасны дагуу төлбөрийг нэхэмжлэлийн дагуу барагдуулж ажилласан. Төлбөрийн баримтыг хавсралтаар орууллаа.